

БАНКНААС БУСАД
САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ
2017 ОНЫ II УЛИРАЛ

УЛААНБААТАР ХОТ
2017 он

АГУУЛГА

I. 2017 ОНЫ II УЛИРЛЫН ХУРААНГУЙ ТОЙМ	
1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ.....	10
1.1.1 Үнэт цаасны зах зээл.....	10
1.1.2 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл.....	10
1.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	10
1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА.....	11
1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО.....	11
II. БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ	
2.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ.....	14
2.1.1 Үнэт цаасны зах зээл.....	14
2.1.2 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл.....	16
2.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	17
2.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА.....	22
2.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО.....	26
2.5 ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН.....	28
III. ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ	
3.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ.....	32
3.1.1 Үнэт цаасны зах зээл.....	32
3.1.2 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл.....	33
3.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	34
3.3 БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖ.....	35
3.3.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА.....	36
3.3.2 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО.....	39
IV. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	
4.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ.....	46
4.1.1 Үнэт цаасны зах зээл.....	46
4.1.2 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл.....	48
4.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	49
4.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА.....	51
4.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО.....	53



V. АШИГТ АЖИЛЛАГАА	
5.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	60
5.1.1 Үнэт цаасны зах зээл	60
5.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ	64
5.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	66
5.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	68
VI. ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	
6.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	72
6.1.1 Үнэт цаасны зах зээл	72
6.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ	74
6.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	81
6.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	83
VII. БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН	
7.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	88
7.1.1 Үнэт цаасны зах зээл	88
7.2 ДААТГАЛ	89
7.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	90
7.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	91
ХАВСРАЛТ	92

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани	15
Хүснэгт 2: Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/	24
Хүснэгт 3: ХЗХ–дын зээлийн ангиллын өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/	37
Хүснэгт 4: Олгосон батлан даалтын тоо, хэмжээ /хүртээмжтэй байдлаар/	29
Хүснэгт 5: Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо	33
Хүснэгт 6: Төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж буй үнэт цаас /мянган ширхэгээр/	47
Хүснэгт 7: Зохицуулалттай этгээдийн тоо	48
Хүснэгт 8: 2017 оны 1 улирлын ХАА–н биржийн арилжааны хэмжээ, дүн	48
Хүснэгт 9: Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/	60
Хүснэгт 10: Нийт орлого /тэрбум төгрөгөөр/	60
Хүснэгт 11: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөгөөр/	62
Хүснэгт 12: Ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/	66
Хүснэгт 13: ХЗХ–дын ашгийн хэмжээ /бүлгээр/	69
Хүснэгт 14: Даатгалын компаниудын хэмжээ	74
Хүснэгт 15: Зээлийн эрсдэл /ББСБ–уудын тоогоор/	82
Хүснэгт 16: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж буй ББСБ–ын тоо	83
Хүснэгт 17: ХЗХ–дын хадгаламжийн үйл ажиллагаа /тэрбум төгрөгөөр/	84

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Зах зээлийн үнэлгээ/тэрбум төгрөгөөр/	14
Зураг 2: ЗЗҮ/ДНБ	15
Зураг 3: ТОП–20 индекс /сараар/	15
Зураг 4: ХАА–н биржийн арилжаа /тэрбум төгрөгөөр/	16
Зураг 5: MAPIX индекс	17
Зураг 6: Даатгалын зах зээлийн бүтэц	17
Зураг 7: Ердийн даатгалын компаниудын хураамжийн орлогын зах зээлд эзлэх хувь	18
Зураг 8: Даатгалын гүнзгийрэлтийн түвшин	19
Зураг 9: Даатгалын салбарын нийт хөрөнгө	19
Зураг 10: Даатгалын компанийн хөрөнгийн өсөлтийн тархалт	20
Зураг 11: Хураамжийн орлого	20
Зураг 12: Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж	21
Зураг 13: Нөөц сангийн хэмжээ, өсөлт	21
Зураг 14: ББСБ–ын тоо ба харилцагчдын тоо	22
Зураг 15: Нийт хөрөнгө ба ДНБ–ий харьцаа	23
Зураг 16: ББСБ–уудын зах зээлд эзлэх хувь	23
Зураг 17: Зээлийн болон активын жилийн өсөлт /хувиар/	24
Зураг 18: Чанаргүй зээлийн ангилал /91 хоногоос дээш хугацаагаар төлөгдөөгүй зээл/	25
Зураг 19: Олгосон зээл, зориулалтаар /хувиар/	25
Зураг 20: ХЗХ–ны бүтэц	26
Зураг 21: ХЗХ–дын тоо болон гишүүдийн тоо	26
Зураг 22: Актив болон зээлийн жилийн өсөлт	27

Зураг 23: Нийт хөрөнгө ба ДНБ-ий харьцаа	28
Зураг 24. Зээлийн батлан даалтын тоо	28
Зураг 25. Батлан даалтын хэмжээ /тэрбум төгрөгөөр/	28
Зураг 26: Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь	32
Зураг 27: Хөдөө орон нутгууд дахь брокеруудын байршил	33
Зураг 28: ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /тэрбум төгрөгөөр/	34
Зураг 29: Даатгалын нягтрал /төгрөгөөр/	34
Зураг 30: Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын салбаруудын байршил /бүсээр/	35
Зураг 31: Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын салбаруудын байршил /дүүргээр/	35
Зураг 32. ББСБ-уудын тархалт.....	36
Зураг 33. ББСБ-ын тоо /аймаг, дүүргээр/.....	36
Зураг 34. Зээлдэгчдийн тоо /дүүргээр/.....	37
Зураг 35. Зээлдэгчдийн тоо /аймгаар/.....	38
Зураг 36: Харилцагчдын тоо /хүйсээр/.....	38
Зураг 37: Зээлдэгчдийн насны бүтэц /тоогоор/.....	39
Зураг 38: ХЗХ-дын тоо /бүс нутгаар/	39
Зураг 39: ХЗХ-дын хүртээмжтэй байдал /дүүргээр –Улаанбаатар/	40
Зураг 40: ХЗХ-дын хүртээмжтэй байдал /бүсээр–Аймаг орон нутаг/	40
Зураг 41: ХЗХ-дын гишүүд /хүйсийн ангиллаар/	41
Зураг 42: ХЗХ-дын гишүүдийн насны бүтэц /интервалаар/	41
Зураг 43: ХЗХ-дын тоо, өсөлтийн хувь	42
Зураг 44: Нэг гишүүнд ногдох хадгаламж, зээлийн хэмжээ бүсээр /сая төгрөгөөр/	42
Зураг 45: Нэг гишүүнд ногдох хадгаламж, зээлийн хэмжээ дүүргээр /сая төгрөгөөр/	43
Зураг 46: Хувьцаат компанийн тоо	46
Зураг 47: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	49
Зураг 48: Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого /бүтээгдэхүүнээр/	50
Зураг 49: Даатгалын төлөөлөгчөөр дамжиж орсон хураамжийн орлого	50
Зураг 50: Даатгалын хохирол үнэлгээний орлого	51
Зураг 51: Үйл ажиллагааны төрөл /давхардсан тоогоор/	51
Зураг 52: ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого/тэрбум төгрөгөөр/	52
Зураг 53: ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс олсон орлого.....	53
Зураг 54: ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс гарсан зардал	54
Зураг 55: Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/	61
Зураг 56: Шинээр IPO, SPO хийсэн компанийн тоо.....	62
Зураг 57: Гадаад хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь.....	63
Зураг 58: Цэвэр ашиг	64
Зураг 59: Цэвэр ахиу, хосолсон харьцаа.....	65
Зураг 60: Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж.....	65
Зураг 61: Ашигт ажиллагаа.....	66
Зураг 62: Хөрөнгийн өгөөж.....	67

Зураг 63: ББСБ тус бүрийн хөрөнгийн өгөөж	67
Зураг 64: ББСБ–уудын өгөөжийн дундаж түвшин	68
Зураг 65: ХЗХ–дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/	68
Зураг 66. ҮЦК–ийн тоо болон зах зээлийн үнэлгээний хамаарал	72
Зураг 67. Индексүүдийн 5 жилийн гулсах корреляци хамаарал	73
Зураг 68. Top 20, Nikkie 225, FTSE 100 индексүүдийн сарын өгөөжийн 6 сарын гулсах дундаж	74
Зураг 69. Судалгаанд хамрагдсан даатгалын компаниудын зэх зээлд эзлэх хэмжээ	75
Зураг 70. Даатгалын компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээ	75
Зураг 71. Эрсдэлийн удирдлагад төсөвлөсөн хөрөнгө	76
Зураг 72. Даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын зорилт	76
Зураг 73. Эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан болон нэгж хэлтэсийг стратегид тусгасан эсэх	77
Зураг 74. Даатгалын компаниудын эрсдэлийн тухай ойлголтын түвшин	77
Зураг 75. Даатгалын компаниуд эрсдэлээ тодорхойлж, нарийвчилсан эсэх	78
Зураг 76. Үр ашигтай эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хүндрэл	78
Зураг 77. Ердийн даатгалын компаниудын эрсдэлийн үнэлгээний тооцооллын аргачлал ..	79
Зураг 78. Даатгалын компаниудын эрсдэлийн үнэлгээнд ашиглаж буй програм хангамж ..	79
Зураг 79. Эрсдэлийн төрөл тус бүрийн стратегийн ач холбогдлын түвшин ба түүнд зарцуулж буй хүн цаг	80
Зураг 80: Чанаргүй зээлийн хувь	81
Зураг 81. Мөнгөн хөрөнгө ба богино хугацаат өр төлбөрийн харьцаа	82
Зураг 82: Нийт зээл болон чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/	83
Зураг 83: ХЗХ–дын зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/	84
Зураг 84: Хэрэгжилтийн байдал	91
ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ	
Шигтгээ 1: Хөрөнгийн зах зээлийн хөгжил	16
Шигтгээ 2: Эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмж	37
Шигтгээ 3: Эмэгтэй бизнес эрхлэгчдийн “бодит” тоо	38
Шигтгээ 4: БЖДҮ–ийн санхүүжилтийн хүртээмж	52
Шигтгээ 5: СЗХ ICURN – ын гишүүн боллоо	54
Шигтгээ 6: OECD орнуудын банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөө:	80
Шигтгээ 7: Алтманы индекс	83
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	
Хавсралт 1: Хөрөнгийн зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	92
Хавсралт 2: Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	93
Хавсралт 3: ББСБ–уудын статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	94
Хавсралт 4: ХЗХ–дын статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	95



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БЖДҮ	Бичил жижиг дунд үйлдвэр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
МББСБХ	Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо
МИК	Монголын ипотекийн корпораци
МҮЦАЭХ	Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо
МХБ	Монголын хөрөнгийн бирж
МХЗХҮХ	Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо
ОССК	Орон сууцны санхүүжилтийн корпораци
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ХК	Хувьцаат компани
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ОЕСД	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
МАРИХ	Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс





2017 ОНЫ
II УЛИРЛЫН
ХУРААНГУЙ ТОЙМ

2017 ОНЫ II УЛИРЛЫН ХУРААНГУЙ ТОЙМ

1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

1.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас үнэт цаасны зах зээлийн хөгжлийг үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, үнэт цаасны арилжааны ДНБ–д эзлэх хувь, зах зээлийн үнэлгээний ДНБ–д эзлэх хувь, хувьцааны индекс гэсэн үндсэн 5 үзүүлэлтүүдээр илэрхийлдэг. Тухайн улсын хувьд дээрх хөгжлийн үзүүлэлтүүд ямар түвшинд байгаагаас хамаарч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэх, хөрөнгө оруулалтын урсгал бий болох, улмаар бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд байгаа эсэхийг тодорхойлдог.

2017 оны 2 дугаар улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1,497.7 тэрбум төгрөг бөгөөд өмнөх улиралтай харьцуулахад 68.4 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар өссөн. Уг өсөлт гарахад “МИК Холдинг” ХК 19.5 хувь, “Таван толгой” ХК 18.0 хувь, “Говь” ХК 10.3 хувь, “Гутал” ХК 23.1 хувиар тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн. Харин зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн улиралтай харьцуулахад 74.6 тэрбум төгрөг буюу 5.2 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд ТОП–20 индексэд багтдаг “Таван толгой” ХК 235.3 хувь, “Говь” ХК 59.1 хувь, “Дархан нэхий” ХК 24.2 хувь, “Талх чихэр” ХК 17 хувиар тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн.

Зах зээлийн үнэлгээний ДНБ–д эзлэх хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 0.1 пунктээр өссөн байна. Харин тайлант хугацаанд нийт 7.2 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар 0.5 хувь байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Тайлант хугацаанд ТОП–20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 386.3 нэгж буюу 3.2 хувиар өсөж, 12,660.4 нэгжид ба индексийн дээд үзүүлэлт 13,235.9, доод үзүүлэлт 11,972.1, дундаж үзүүлэлт 12573.8 нэгж байна. MSE ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.4 нэгж буюу 1.2 хувиар буурч, 860.5 нэгжид хүрэв. Тус индексийн дээд үзүүлэлт 868.0 нэгж, доод үзүүлэлт 814.5 нэгж, дундаж үзүүлэлт 838.8 нэгж байна.

1.1.2 ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

ХАА–н бирж 2017 оны 2 дугаар улиралд нийт 393.4 тэрбум төгрөгийн 6,237 тоннын арилжааг нийт 54 өдөрт явуулав. Арилжигдсан барааны хэмжээний 79 хувийг ямааны

ноолуур, 10 хувийг хонины завод ноос, 8 хувийг хонины ноос, 2 хувийг ямааны завод ноос, 1 хувийг тэмээний ноосны арилжаа тус тус бүрдүүлсэн.

1.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улсын даатгалын зах зээлийн нийт хөрөнгийн өсөлтийн 62.8 хувийг хөрөнгө оруулалтын өсөлт бүрдүүлсэн бол нөгөө талдаа эх үүсвэрийн өсөлтийн 56.1 хувийг нөөц сангийн өсөлт тайлбарлалаа. Өөрөөр хэлбэл, даатгалын салбарт нөөц сангаас үүдэлтэй хөрөнгийн өсөлт бий болов. Түүнчлэн салбарын хэмжээнд 85.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой, 6.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллав. Сүүлийн жилүүдэд нийт хураамжийн орлогод эзлэх давхар даатгалын хураамжийн зардал бусад зардалтай харьцуулахад маш өндөр байгаа төдийгүй, цэвэр ашгийн өсөлтөд тогтмол төлөв ажиглагдаж байна.

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2016 оны мөн үетэй харьцуулахад 23.9 хувиар өсөж, 249.4 тэрбум төгрөгт хүрэв. Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.2 хувиар өссөн. Энэхүү өсөлтийн 21.8 хувийг даатгалын авлагын өсөлт, 21.2 хувийг хөрөнгө оруулалтын өсөлт, 11.5 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт тус тус тайлбарлаж байна. Харин эх үүсвэр талд нийт өр төлбөр ба эзний өмчийн өсөлтийн 51.5 хувийг нөөц сангийн өсөлт, 21.3 хувийг даатгалын өглөг, 18.5 хувийг хуримтлагдсан ашиг бүрдүүлжээ.

Ердийн даатгалын компаниуд нийт 83.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласан ба давхар даатгалын хураамжийн зардалд 41.8 хувийг, нийт нөхөн төлбөрийн зардалд 19.9 хувийг, үйл ажиллагааны зардалд 24.1 хувийг зарцуулсан. Ердийн даатгалын компаниудын татварын дараах цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 31.9 хувиар өссөн.

Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 7.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 157.8 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар өсөв. Үндсэн хөрөнгийн 90.5 сая төгрөгийн бууралт нийт хөрөнгийн өсөлт саарахад голчлон нөлөөлөв. Нийт хөрөнгийн 56.8 хувийг хөрөнгө оруулалтын дүн эзэлж байгаа бөгөөд үүнээс хадгаламж, хадгаламжийн сертификат 19.3 хувь, үнэт цаас 37.5 хувийг тус тус бүрдүүллээ. Хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулах хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө оруулалтын

бүтцэд томоохон өөрчлөлт оров. Өөрөөр хэлбэл үнэт цаасны хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.8 тэрбум төгрөгөөр буюу 187.7 хувиар өссөн бол хадгаламж хадгаламжийн сертификат 1.7 тэрбум төгрөгөөр буюу 54.5 хувиар буурчээ.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд 0.7 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны эхний хагас жилээс 23.8 хувиар өссөн үзүүлэлт байв. Нийт даатгалын хураамжийн орлогоос давхар даатгал, нөхөн төлбөр, үйл ажиллагааны зардлуудын дүн давсан ба 2016 оны мөн үетэй харьцуулахад 27.9 хувиар өссөн байна. Хэдий тийм боловч 359.4 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн бус орлого нь 109.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллах үндэс болов.

Давхар даатгалын компанийн нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.3 хувиар өсөв. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хөрөнгө оруулалтын дүн өмнөх оны мөн үеэс 2.3 дахин өссөн бөгөөд нийт хөрөнгийн 94.5 хувийг эзэлжээ. Хөрөнгө оруулалтын бүтцийн хувьд урт хугацааны даатгалын компаниас ялгаатай байна. Нийт хөрөнгө оруулалтын 76.6 хувийг хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэрээр байршуулсан хөрөнгө оруулалт, 23.4 хувийг үнэт цаасаарх хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлэв. Хөрөнгө оруулалтын өсөлт өндөр байсан боловч мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн бууралт өндөр байсан нь нийт хөрөнгийн өсөлтийн хурдыг сааруулав.

Давхар даатгалын компанийн татварын дараах цэвэр ашиг 2.5 дахин өсөж 2.5 тэрбум төгрөгт хүрэв. Нийт нөхөн төлбөрийн зардал 580.6 сая төгрөг буюу давхар даатгалын нийт хураамжийн орлогын 57.6 хувийг эзэлж байгаа бол үйл ажиллагааны зардал болон нийт хураамжийн орлогын харьцаа 87.6 хувь байна. Урт хугацааны даатгалын компаниаг адил давхар даатгалын компанийн даатгалын хураамжийн бус орлогын дүн өндөр буюу 1.4 тэрбум төгрөг байгаа нь цэвэр ашгийн дүнг зэрэг гарахад нөлөөлөв.

1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Тайлант хугацаанд нийт 533 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагийн 467 нь Улаанбаатар хотод, хөдөө орон нутагт 66 ББСБ байгаа бөгөөд 46 ББСБ-ын нийт 126 салбар байна.

ББСБ-уудын нийт хөрөнгө 855.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 179.3 тэрбум төгрөгөөр буюу 26.5 хувиар, энэ оны өмнөх улирлаас 57.5 тэрбум төгрөг буюу 6.7 хувиар тус тус өссөн. Үүнд, итгэлцлийн үйлчилгээний өглөг болон гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагаас татсан зээлийн санхүүжилт нэмэгдсэнээр нийт өр төлбөр энэ оны өмнөх улирлаас 11.6 тэрбум төгрөг буюу 6.6 хувиар, мөн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хуримтлагдсан ашиг өссөн нь эздийн өмчийг энэ оны өмнөх улирлаас 45.9 тэрбум төгрөг буюу 6.7 хувиар тус тус нэмэгдүүлсэн нь

нөлөөлжээ. Ингэснээр ДНБ-д эзлэх ББСБ-ын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 12.1 хувийг эзэлж байна.

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар 89.5 тэрбум төгрөгийн нийт орлоготой ажиллаж 28.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай буюу 31 хувийн ахиу ашигтай ажиллав. Нийт орлогын 73.6 тэрбум төгрөг буюу 82.3 хувийг зээлийн хүүгийн орлого, 12.6 тэрбум төгрөг буюу 14.2 хувийг бусад бүтээгдэхүүн үйлчилгээнээс, 3.2 тэрбум төгрөг буюу 3.5 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлогоос тус тус олжээ.

Нийт зардлын 40.0 тэрбум төгрөг буюу 65.1 хувийг үйл ажиллагааны болон бусад үйлчилгээний зардал, 10.2 тэрбум төгрөг буюу 16.6 хувийг болзошгүй эрсдэлийн зардал, 6.9 тэрбум төгрөг буюу 11.3 хувийг хүүгийн зардал, 3.5 тэрбум төгрөг буюу 5.8 хувийг ААН-ийн орлогын албан татварын зардал, 0.8 тэрбум төгрөг буюу 1.3 хувийг үндсэн бус үйл ажиллагааны зардал бүрдүүлсэн байна.

ББСБ-уудын хугацаа хэтэрсэн зээлийн хувь 5.9, чанаргүй зээлийн хувь 13.0 ба нийт зээлд эзлэх зээлийн эрсдэлийн сангийн харьцаа 8.5-тай гарлаа.

Тайлант улиралд 7 ББСБ шинээр тусгай зөвшөөрөл авснаар 100,000 иргэнд ногдох ББСБ-ын тоо Улаанбаатар хотод 41, хөдөө орон нутагт 6 болж тус тус 1 нэгжээр нэмэгдсэн. Мөн Говь-Алтай аймагт анхны ББСБ-ын тусгай зөвшөөрлийг авсан байна.

1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тайлант улиралд 12 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 30 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, 6 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэж 2017 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 287 хадгаламж, зээлийн хоршоо Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Тайлант улиралд ХЗХ-ны тоо өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар, гишүүдийн тоо 15.8 хувиар, нийт активын хэмжээ 22.8 хувиар тус тус өссөн байна. ХЗХ-ны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 21.1 хувиар өссөн, тайлант үеийн цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 19 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

Хорооноос төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөл авч, “Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн хөтөлбөр”-т хамрагдсан 123 ХЗХ байгаагаас 118 ХЗХ нь уг хөтөлбөрийг батлагдсанаас хойш тайлант улиралд Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн нийт 15.4 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурсан байна.





БАНКНААС БУСАД
САНХҮҮГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


2.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ: Зах зээлийн үнэлгээ нь үнэт цаасны зах зээл дээр арилжаалагдсан хувьцааны нийлбэр дүнгээр илэрхийлэгддэг. Зах зээлийн хэмжээ, багтаамж, түүний эдийн засгийн өсөлтийг дунд болон урт хугацаанд дэмжигч гол үзүүлэлт нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээ.

Энэхүү үзүүлэлтийн өсөлт, бууралт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг, улмаар эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөө үзүүлж байгааг илэрхийлэгч үндсэн индикатор болдог.

Зураг 1: Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 2 дугаар улирлын байдлаар үнэт цаасны нийт зах зээлийн үнэлгээ 1,497.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 74.6 тэрбум төгрөг буюу 5.2 хувиар, 2016 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад 23.5 тэрбум төгрөг буюу 1.6 хувиар, 1 дүгээр улиралтай харьцуулахад 68.4 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар өссөн байна.

2017 оны 2 дугаар улиралд 68.4 тэрбум төгрөгийн өсөлт гарахад “МИК Холдинг” ХК, “Таван толгой” ХК, “Говь” ХК, “Гутал” ХК-ийн хувьцааны ханш 19.5%, 18.0%, 10.3%, 23.1%-аар тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн бол

“АПУ” ХК, “БиДиСек” ХК, “Тахь Ко” ХК, “Мерекс” ХК –ийн хувьцааны ханш 15.9%, 11.2%, 9.7%, 39.3%-аар тус тус буурсан байна.

Тайлант хугацаанд нийт зах зээлийн үнэлгээний 90.4 хувийг топ 30 компани бүрдүүлж байгаа бөгөөд эдгээр компаниудын ихэнх нь уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нь уул уурхайн салбарын өсөлт, бууралттай холбоотойгоор дотоодын үнэт цаасны зах зээлийн үнэлгээнд шууд нөлөө үзүүлж байна. Үүнд:

Хүснэгт 1: Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани

№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/	№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/
1	ТАВАН ТОЛГОЙ	252.5	16	БИДИСЕК	20.2
2	МИК ХОЛДИНГ	252.4	17	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	18.2
3	АПУ	215.5	18	БЭРХ УУЛ	16.0
4	ГОВЬ	101.8	19	БАЯНГОЛ ЗБ	15.3
5	УБ БҮК	52.3	20	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	13.0
6	СҮҮ	47.2	21	ТЕХНИКИМПОРТ	11.7
7	МОНГОЛ ШУУДАН ХК	38.6	22	ГЕРМЕС ЦЕНТР	11.4
8	БАГАНУУР	37.7	23	МАТЕРИАЛИМПЕКС	10.9
9	ШИВЭЭ ОВОО	33.4	24	АТАР ӨРГӨӨ	10.8
10	ГУТАЛ	27.5	25	ХӨХ ГАН	10.1
11	МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС	26.7	26	СИЛИКАТ	9.5
12	ШАРЫН ГОЛ	23.4	27	МАХИМПЕКС	9.1
13	ТАХЬ КО	23.2	28	АРИГ ГАЛ	8.5
14	ДАРХАН НЭХИЙ	22.7	29	АДУУНЧЛУУН	6.6
15	ТАЛХ ЧИХЭР	22.2	30	ЖЕНКО ТҮР БҮРО	6.4


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2.1.1.1 ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (ЗЗҮ)–НИЙ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН (ДНБ)–Д ЭЗЛЭХ ХУВЬ, ХӨРВӨХ ЧАДВАРЫН ТҮВШИН

2017 оны 2 дугаар улирлын нийт ЗЗҮ–г 2016 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ–ний хэмжээтэй харьцуулахад 6.26 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.11 пунктээр өссөн байна.

Харин тайлант хугацаанд нийт 7.2 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар 0.48 хувь байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.14 пунктээр өссөн байна.

Зураг 2: ЗЗҮ/ДНБ




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны зах зээлийн индексүүд: Тайлант хугацаанд ТОП–20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1 хувиар өсч, 12,660.4 нэгжид хүрсэн бөгөөд индексийн дээд үзүүлэлт 13235.9, доод үзүүлэлт 11972.1, дундаж үзүүлэлт 12573.8 нэгж байна.

MSE ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 хувиар буурч, 860.5 нэгжид хүрчээ. Тус индексийн дээд үзүүлэлт 868.0 нэгж, доод үзүүлэлт 814.5 нэгж, дундаж үзүүлэлт 838.8 нэгж байна.

Зураг 3: ТОП–20 индекс /сараар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ШИГТГЭЭ 1:

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011 онд уул уурхайн салбарын өсөлттэй холбоотойгоор 17.5 хувьд хүрч, бүс нутаг болоод олон улсын хэмжээнд эдийн засгийн өсөлтийн хурдаар тэргүүлэх болсон бөгөөд үүнтэй холбоотойгоор Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, ТОП-20 индексийг бүрдүүлэгч уул уурхайн салбарын компаниудын хувьцааны ханш огцом нэмэгдэх болсон. Үүнийг дагаад манай улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон мэргэжлийн зуучлагч брокеруудын тоо ихээр нэмэгдсэн байна. Гэвч 2012 оноос хойших хугацаанд олон улсын санхүүгийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ ханш унасан, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан, эдийн засгийн өсөлт удааширсан зэрэг шалтгаануудын улмаас манай хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд буурсаар байна.

Хэдийгээр хөрөнгийн зах зээлийн хөгжлийн суурь нөхцөл болох үнэт цаасны зах зээлийн хууль, эрх зүйн орчин сүүлийн жилүүдэд сайжирч, хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоо бүрдэх боломж бий болж байгаа хэдий ч, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжил сул, тэр дундаа төлбөр, тооцоо, арилжааны систем болон мэргэжлийн зуучлагч байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй, хангалттай хэмжээний шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт хомс, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадвар доогуур, үр ашигтай хяналт, зохицуулалтын механизм бүрдээгүй зэрэг нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд сөрөг нөлөөг үзүүлж байна.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


2.1.2 ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

ХАА–н биржийн хөгжил: Монгол Улсын Их Хурлаас 2011 онд баталсан Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГ–ын 30 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 45 дугаар тогтоол гарч “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК–ийг үүсгэн байгуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг томилсон. ХАА–н бирж нь свот болон үүсмэл гэрээний арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, биржийн арилжаанд оролцогчдыг сургах, мэргэшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримталдаг.

Хөдөө аж ахуйн бирж нь анх 2013 оны дөрөвдүгээр сарын 05–ны өдрөөс хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалж эхэлсэн ба 2017 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 4 жилийн хугацаанд нийт 2,276.6 тэрбум төгрөгийн 757 удаагийн арилжаа явуулжээ.

ХАА–н биржээр дамжин 2014 оны хоёрдугаар улиралд 311.5 тэрбум, 2015 оны хоёрдугаар улиралд 396.6 тэрбум, 2016 оны хоёрдугаар улиралд 269.4 тэрбум, 2017 оны хоёрдугаар улиралд 393.4 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгджээ. Харин 2017 оны хоёрдугаар улиралд арилжсан бараа, түүхий эдийн хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 97.6 тэрбум төгрөг буюу 33 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

Зураг 4: ХАА–н биржийн арилжаа /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтээс шалтгаалан 1 болон 4 дүгээр улирлуудад арилжааны хэмжээ буурдаг ба 2

болон 3 дугаар улирлуудад свот арилжаа идэвхэждэг.

ХАА-Н БИРЖИЙН ИНДЕКС

Зураг 5: МАРИХ индекс



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээлийн бүтэц: Тайлант хугацаанд нийт 272 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор СЗХ-ноос олгосон

тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 6: Даатгалын зах зээлийн бүтэц

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын зах зээлд өнөөгийн байдлаар ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, давхар даатгалын 1 компани үйл ажиллагаа явуулж байна. Харин мэргэжлийн оролцогчдын хувьд 40 даатгалын зуучлагч компани байгаагаас давхар даатгалын зуучлагч 9, мөн даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлэгч 9 банк байна. Даатгалын хохирол үнэлэгч 31 компани, 3095 даатгалын төлөөлөгчид тус тус СЗХ–ноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилго бүхий, төрийн бус байгууллагууд СЗХ–той санамж бичгийн хүрээнд хамтран ажилладаг. Эдгээр холбоодыг дурдвал Албан журмын даатгагчдын холбоо, Монголын даатгагчдын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын хохирол үнэлэгчдийн холбоо зэрэг юм.


Даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдын санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа стандартын дагуу хөтлөгдөж буй эсэхэд хяналт тавих,

баталгаажуулах үүднээс аудитын компаниудад СЗХ–ноос эрх олгодог. Одоогоор нийт 42 аудитын компани болон 126 аудиторт тус эрхийг олгоод байна.

2017 оны 2 дугаар улирлын байдлаар нэр бүхий нэг даатгалын компани ердийн даатгалын нийт хураамжийн орлогод эзлэх хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 2.4 хувиар өсөж 25.1 хувьд хүрэн зах зээлд хамгийн өндөр хувийг эзэлсэн хэвээр байна. Түүний араас нэр бүхий 2 даатгалын компани нийт хураамжийн орлогын хэмжээгээрээ тус тус ердийн даатгалын зах зээлийн 15.7 болон 18.5 хувийг эзэлж байна.

2016 оны мөн үед дээр дурдсан 3 даатгагчид ердийн даатгалын зах зээлийн хураамжийн орлогын 52.4 хувийг эзэлж байсан бол уг үзүүлэлт тайлант улиралд 6.9 хувиар өсөж, 59.3 хувь болов. Бусад ердийн даатгалын компаниудын хувьд зах зээлд эзлэх хураамжийн орлогын хэмжээ ойролцоо түвшинд буюу 0.1–ээс 8.6 хувийн хооронд, дунджаар 3.4 хувь байна.

Зураг 7: Ердийн даатгалын компаниудын хураамжийн орлогын зах зээлд эзлэх хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын гүнзгийрэлтийн түвшин: Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ–д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ олон улстай харьцуулахад доогуур байна. Хэдий тийм боловч 2017 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын гүнзгийрэлт 1.21 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.65 хувиар өссөн үзүүлэлт юм.

Олон улсын хандлагаас харахад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт ердийн даатгалаас илүү өндөр хувьтай

байдаг бол манай орны хувьд нөхцөл байдал эсрэгээрээ байна. Европын болон Азийн зарим орнуудад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт 5 хувиас дээш, Өмнөд Африк болон Ирландад 10 хувиас дээш байхад манай орны хувьд сүүлийн жилүүдэд дунджаар 0.01 хувьтай байгаа юм. Харин OECD–ийн гишүүн орнуудын ердийн даатгалын гүнзгийрэлт 2015 оны байдлаар 4.4 хувь байхад манай орны хувьд тайлант хугацаанд 1.18 хувь байна.

Зураг 8: Даатгалын гүнзгийрэлтийн түвшин




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт хөрөнгө: Тайлант хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23.9 хувь, өмнөх улирлаас 11 хувиар өсөж 249.4 тэрбум төгрөгт хүрлээ. Давхар даатгалын компанийн нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад хамгийн өндөр буюу 23.7 хувиар өсөж 41 тэрбум төгрөг болж, нийт хөрөнгийн 16.4 хувийг

эзлэв. Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 24.2 хувиар өсөж 200.9 тэрбум төгрөг болсон нь салбарын нийт хөрөнгийн 80.5 хувийг, харин урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 2.1 хувиар өсөж 7.5 тэрбум төгрөгт хүрч, нийт хөрөнгийн 3 хувийг эзэллээ.

Зураг 9: Даатгалын салбарын нийт хөрөнгө




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 2016 оны 2 дугаар улиралд 17 хувь байсан бол 2017 оны мөн үед 20 хувьтай байна. 2016 онд дунджаас дээш хөрөнгийн өсөлттэй компанийн тоо 7 байсан бол 2017

онд 5 болж буурсан байна. Харин 2016 болон 2017 оны 2 дугаар улиралд даатгалын компаниудын хөрөнгийн өсөлтийн тархалт интервал тус бүрд ижил байна.

Зураг 10: Даатгалын компанийн хөрөнгийн өсөлтийн тархалт

ДААТГАЛЫН КОМПАНИУД	2016/2015	2017/2016
Монре даатгал	14.2%	10.7%
Ард даатгал	12.5%	9.5%
Бодь даатгал	32.6%	54.0%
Мөнх даатгал	1.1%	3.9%
Миг даатгал	10.0%	20.9%
Соёмбо даатгал	3.4%	9.5%
Монгол даатгал	7.5%	16.5%
Тэнгэр даатгал	19.1%	34.3%
Номин даатгал	20.0%	15.6%
Улаанбаатар хотын даатгал	-1.1%	1.6%
Гэр даатгал	11.9%	16.4%
Ган зам даатгал	25.3%	14.4%
Практикал даатгал	24.3%	13.5%
Мандал жeneral даатгал	44.2%	68.3%
Хаан даатгал	11.9%	18.2%
Нэйшнл лайф даатгал	10.3%	2.1%
Хөдөө аж ахуйн давхар даатгал	33.7%	27.3%
ДУНДАЖ	16.5%	19.8%




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хураамжийн орлого: Даатгалын компаниуд энэ оны эхний хагас жилд нийт 85.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллав. Үүнээс ердийн даатгалын компаниуд 83.8 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компани 0.7 тэрбум төгрөг, давхар даатгалын компани 1 тэрбум төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлэв. 2016 оны эхний хагас жилд хураамжийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.5 хувийн бууралттай гарч байсан бол 2017 онд 40 хувийн өсөлтийг үзүүлэв.

Хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг авч үзвэл даатгалын зуучлагчид 15.4 тэрбум төгрөг буюу 18 хувийг, даатгалын төлөөлөгчид 15.7 тэрбум төгрөг буюу 18.4 хувийг бүрдүүлсэн байна. Даатгалын зуучлагчаар дамжин орсон хураамжийн орлогын 40.9 хувийн жолоочийн хариуцлагын албан журмын даатгал эзэлж байгаа бол төлөөлөгчөөр дамжин орсон хураамжийн орлогын 35.9 хувийг эзэлж байна.

Зураг 11: Хураамжийн орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж: Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант улиралд 17.3 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 20.2 хувийг эзлэв. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 96.2 хувийг бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 5.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эхний хагас жилд нийт 35.5 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг шилжүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 79.4 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт хураамжийн орлогын 41.5 хувийг эзэлж байна. Ердийн даатгалын компаниуд давхар даатгалд 35 тэрбум төгрөг, давхар даатгалын компани 428 сая төгрөг, урт хугацааны даатгалын компани 12.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг 12: Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөөц сан: Даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ энэ оны эхний хагас жилийн байдлаар 122.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 27.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Эхний хагас жилийн харьцуулсан үзүүлэлтээс харахад 2010 оноос хойш нийт нөөц сангийн өсөлт дунджаар 26.1 хувьтай, 9 хувийн стандарт хазайлттай байв.

Тайлант улиралд ердийн даатгалын компаниудын нийт нөөц сан (орлогод тооцоогүй хураамжийн нөөц болон нөөц сангийн нийлбэр дүн)-ийн хэмжээ 24.6 хувиар өсөж 101.9 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компанийн нөөц сан 2.9 хувиар буурч 1.4 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 49.6 хувиар өсөж 18.9 тэрбум төгрөг болов.

Зураг 13: Нөөц сангийн хэмжээ, өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөөц сангийн хөрөнгийн 50 орчим хувь нь арилжааны банкуудад хадгаламж болон хадгаламжийн сертификат хэлбэрээр байршиж байна.


2.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-ын тоо ба харилцагчдын тоо: 2017 оны 2 дугаар улирлын байдлаар нийт ББСБ-ын тоо 533-д хүрч өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар, өмнөх улирлаас 0.8 хувиар нэмэгдсэн бол харилцагчдын тоо 1.35 саяд хүрлээ. 2017 онд харилцагчдын тоо огцом өссөн нь цахим мөнгөний харилцагчдын бүртгэлийг нэмсэнтэй холбоотой. Монгол Улсын хэмжээнд 1.2 сая иргэн цахим төлбөр тооцоог үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нь санхүүгийн үйлчилгээг

технологид суурилсан байдлаар хэрэглэгчдэд хүргэх нь оновчтойг илтгэж байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос¹ үүрэн холбооны хэрэглэгчдийн тоог 2016 онд 3.4 сая ба үүнээс ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо 2.4 сая, интернет хэрэглэгчдийн тоо 2.7 сая гэж мэдээлсэн ба цаашид технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэхэд олон нийт харьцангуй сайн хэрэглээтэй байна.

Зураг 14: ББСБ-ын тоо ба харилцагчдын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын эдийн засагт үзүүлэх нөлөө: 2017 оны 2 дугаар улирлын байдлаар нэрлэсэн ДНБ болон нийт хөрөнгийн харьцаа 12.1 хувь байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 5.9 нэгжээр өссөн байна. Үүнд, нэрлэсэн ДНБ 35 хувиар буурч, нийт хөрөнгө 26 хувиар өссөн нь нөлөөлсөн.


ББСБ-уудаар арилжааны банкнаас зээл авах шаардлагыг хангаагүй, барьцаа хөрөнгийн үнэлгээг банкнаас өндөр үнэлүүлэх сонирхолтой иргэд, аж ахуй нэгжүүд үйлчлүүлдэг бөгөөд тэдгээр харилцагчид эрсдэл өндөртэй бүлэгт хамаарагдах тул зээлийн эрсдэлийн хэмжээ нэмэгдсэнээр өндөр хүүтэй зээл авах нөхцөл бүрддэг. Нөгөө талаас ББСБ-аас зээл хүсэж буй

харилцагчийн талаар тодорхой мэдээлэл байдаггүйн улмаас мэдээллийн тэгш бус байдал (adverse selection)-д үндэслэн шийдвэр гаргах эрсдэл байдаг тул хүүгийн хэмжээ өндрөөр тогтох нөхцөл бүрддэг. Гэвч зээлийн өндөр хүү нь харилцагчийг зээлээ эргэн төлж чадахгүй байдалд хүргэдэг тул ББСБ-уудад зээлийн эрсдэл үүсгэх гол хүчин зүйлсийн нэг болоод байна.

Иймд харилцагчдад тулгарч буй зээлийн хүүгийн дарамт болон ББСБ-д учирч буй харилцагчаа таньж мэдэхэд оролцогч талууд хоорондын мэдээллийн санг үүсгэх шаардлага үүслээ.

¹ <http://www.crc.gov.mn/k/35/23>

Зураг 15: Нийт хөрөнгө ба ДНБ-ий харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зах зээлд эзлэх хувь: ББСБ-уудын тоо нэмэгдэж байгаа ч хөрөнгө болон орлогын хэмжээгээр зах зээлд эзлэх хувь

нь ижил түвшинд байна. Ихэнх ББСБ-ууд зах зээлийн 0.3 хувиас бага хэсгийг жигд эзэлж байна.

Зураг 16: ББСБ-уудын зах зээлд эзлэх хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн болон активын жилийн өсөлт: Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар, оны эхнээс 8.7 хувиар өсөж, 855.8 тэрбум

төгрөгт, нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 142.9 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 76.7 тэрбум төгрөгөөр өсөж, 554.9 тэрбум төгрөгт хүрлээ.

Зураг 17: Зээлийн болон активын жилийн өсөлт /хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн мэдээлэл: Нийт зээлийн 518.8 тэрбум төгрөг буюу 93.5 хувь нь төгрөгийн, 36.2 тэрбум төгрөг буюу 6.5 хувь нь валютаар олгосон зээл байна.

Төгрөгөөр олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 144.9 төгрөгөөр буюу 38.8 хувиар өссөн бол валютаар олгосон зээлийн хэмжээ 2 тэрбум төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Салбарын зээлийн өсөлт сүүлийн 18 улирал дараалан эерэг гарав. Үүнд банкны салбарын зээлийн нөхцөл

чангарсан, эдийн засгийн идэвхжил удааширсан, банкнууд зээлээ хумьсан зэрэг хүчин зүйлс нөлөөлөв.

2014 оны хоёрдугаар улиралд зээлийн жилийн өсөлт өмнөх оны мөн үеэс 50.6 хувиар өсөөд байсан бол 2015 оноос эхлэн өсөлт нь харьцангуй удааширч 2017 оны хоёрдугаар улиралд 34.7 хувьд хүрлээ.

Нийт зээлийн үлдэгдлийн 81.1 хувийг хугацаандаа байгаа зээл, 5.9 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 13 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна.


Хүснэгт 2. Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/

№	Ангилал	2016-II	2017-II	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
1	Хэвийн	330.9	449.8	118.9	35.9
2	Хугацаа хэтэрсэн	32.1	32.9	0.8	2.5
3	Чанаргүй:	49.1	72.2	23.1	47.0
	Хэвийн бус	14.1	12.5	(1.6)	(11.3)
	Эргэлзээтэй	12.2	18.1	5.9	48.4
	Муу	22.8	41.6	18.8	82.5
4	(Зээлийн эрсдэлийн сан)	33.5	47.4	13.9	41.5
Нийт зээл		412.1	554.9	142.8	34.7
1	Үүнээс: Төгрөгийн	373.9	518.7	144.8	38.7
2	Гадаад валютын	38.2	36.2	(2.0)	(5.2)

Хугацаа хэтэрсэн зээл: 208 ББСБ хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байгаа ба 94.7 хувь нь 40 хувь хүртэл, үлдсэн 5.3 хувь нь 40.1 хувиас дээш хэмжээний хугацаа хэтэрсэн зээлтэй байна.

267 ББСБ чанаргүй зээлийн үлдэгдэлтэй, үүнээс 83.5 хувь нь 40 хүртэл, 16.5 хувь нь 40.1 хувиас дээш хэмжээгээр зээл нь чанаргүйджээ. Түүнчлэн ББСБ-ууд зээл олгохдоо 568.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг барьцаалсан байна.

Зураг 18: Чанаргүй зээлийн ангилал /91 хоногоос дээш хугацаагаар төлөгдөөгүй зээл/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд нийт 33 ББСБ 2.1 тэрбум төгрөгийн зээлийг зээлийн эрсдэлийн сангаас хаасан байна.


Зээлийн зориулалт: 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 314.3 тэрбум төгрөгийн зээл олгож, үүнээс 236.8 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, нийт зээлийн өрийн үлдэгдэл 554.9 тэрбум төгрөг байна. Нийт зээлийн үлдэгдлийн 114.3 тэрбум төгрөг буюу 20.6 хувийг хувийн хэвшилд, 440.6 тэрбум төгрөг буюу 79.4 хувийг иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл шинээр олгосон зээлийн 45.5 хувь буюу 142.9 тэрбум төгрөг нь хэрэглээ, 22.2 хувь буюу 69.9 тэрбум төгрөг нь худалдааны салбар, 11.3 хувь буюу 35.6 тэрбум төгрөг

нь барилгын салбар, 3.8 хувь буюу 12 тэрбум төгрөг нь уул уурхайн салбар, 3.3 хувь буюу 10.3 тэрбум төгрөг нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар, үлдэх 22.7 хувь буюу 71.4 тэрбум төгрөг нь бусад салбаруудад тус тус олгогдсон байна.

Нийт олгосон зээлийн эргэн төлөлтийг эдийн засгийн гол салбараар авч үзвэл хэрэглээний зээлээс 106.1 тэрбум төгрөг, худалдааны салбараас 56.1 тэрбум төгрөг, барилгын салбараас 31.3 тэрбум төгрөг, уул уурхайн салбараас 5.6 тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрлэлийн салбараас 6.3 тэрбум төгрөг, бусад салбараас 31.4 тэрбум төгрөг эргэн төлөгдсөн байна.

Зураг 19: Олгосон зээл, зориулалтаар /хувиар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хорооноос зохицуулалттай үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоо нь 2017 оны 2 дугаар улирлын байдлаар 287 байгаа ба үүнээс Улаанбаатар хотод 67 хувь, хөдөө орон нутагт 33 хувийг тус тус эзэлж байна. Хөдөө орон нутагт нийт 96 ХЗХ-ноос бүсээр харьцуулбал баруун аймгуудад илүү олон ХЗХ үйл ажиллагаа явуулж байна.

ХЗХ нь гишүүдээсээ хадгаламж татах, гишүүддээ зээл олгох зэрэг болон санхүүгийн бусад үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд 2014 оноос нийслэлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ХЗХ-д байгуулснаар хоршоодын тооны өсөлт огцом нэмэгдсэн.

Зураг 20: ХЗХ-ны бүтэц




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын тоо: ХЗХ-дын нийт тоо өнгөрсөн оны мөн улиралтай харьцуулахад 3.6 хувиар өссөн бол гишүүдийн

тоо 15.8 хувиар буюу 6,932 гишүүдээр нэмэгдсэн байна.

Зураг 21: ХЗХ-дын тоо болон гишүүдийн тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Доорх графикаас зээлийн болон хөрөнгийн жилийн өсөлтийг 2013 оноос тайлант он хүртэл харуулсан. Үүнээс өсөлтийг харвал зээлийн өсөлтийн савлагаа хөрөнгөөс

харьцангуй өндөр бөгөөд тухайн өсөлт нь 1 дүгээр улиралд илүү өндөр ажиглагдаж байна.

Зураг 22: Актив болон зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 2 дугаар улиралд ХЗХ-дын нийт зээлийн 95.7 хувийг хэвийн зээл эзлэх бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31 хувиар өссөн байна. Харин хугацаа хэтэрсэн зээл, хэвийн бус зээл, эргэлзээтэй зээлүүд

тодорхой хэмжээгээр өссөн байна. Чанаргүй зээлийн өсөлт мөн оны өмнөх үетэй харьцуулахад 21 хувиар өссөн ба түүний бүрдэл болох муу зээл 83 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 3: ХЗХ-дын зээлийн ангиллын өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/


Зээлийн ангилал	2016.II	2017.II	Өөрчлөлт	
			Хувь	Дүн
Хэвийн зээл	73.0	95.7	31%	22.6
Хугацаа хэтэрсэн зээл	4.1	3.8	-6%	-0.2
Чанаргүй зээл:	4.0	4.8	21%	0.8
Хэвийн бус зээл	1.5	1.4	-11%	-0.2
Эргэлзээтэй зээл	1.2	1.2	-1%	0.0
Муу зээл	1.2	2.3	83%	1.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Эдийн засагт үзүүлэх нөлөө: Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ 129.5 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 22.8 хувиар өссөн байна. 2017 оны 2 дугаар улиралд ХЗХ-дын нийт хөрөнгийн хэмжээг ДНБ-д дүнд

харьцуулахад 1.8 хувийг эзэлж байгаа бөгөөд бусад онуудтай харьцуулахад хамгийн өндөр хувьтай байна.

Зураг 23: Нийт хөрөнгө ба ДНБ-ий харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2.5 ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргах тоо буурсан ба үүнийг дагаад олгосон батлан даалтын хэмжээ мөн багасжээ. 2016 оны 2 дугаар улиралд 16 зээлд батлан


даалт гаргасан бол энэ оны 2 дугаар улиралд 9 батлан даалт гаргасан нь 2016 оны мөн үеэс 56 хувиар буурсан байна.

Зураг 24. Зээлийн батлан даалтын тоо



Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

Зураг 25. Батлан даалтын хэмжээ /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

2.5.1. НИЙТ ОЛГОСОН БАТЛАН ДААЛТ ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР

2017 оны 2 дугаар улирлын байдлаар нийт батлан даалтыг хүртээмжээр нь буюу газарзүйн байршлаар нь харвал Улаанбаатар хотод 693.0 сая төгрөг буюу 41.3 хувь, Төвийн бүсэд 665 сая төгрөг буюу 39.6 хувь, Баруун

бүсэд 12.5 сая төгрөг буюу 0.7 хувь, Хангайн бүсэд 296 сая төгрөг буюу 17.6 хувь, Зүүн бүсэд 12.0 сая төгрөг буюу 0.7 хувийг тус тус олгосон байна.

Хүснэгт 4. Олгосон батлан даалтын тоо, хэмжээ /хүртээмжтэй байдлаар/

Газарзүйн байршил	Батлан даалтын тоо	Батлан даалтын хэмжээ (сая төгрөг)	Батлан даалтын хэмжээ / хувиар/
Баруун бүс	1	12.5	0.7%
Хангайн бүс	2	296.0	17.6%
Төвийн бүс	3	665.0	39.6%
Зүүн бүс	1	12.0	0.7%
Улаанбаатар	2	693.0	41.3%
Нийт	9	1678.5	100.0%

Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

Улаанбаатар хот болон төвийн бүсэд олонх батлан даалтыг олгосон нь хүн ам болон үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжийн төвлөрөлтэй холбоотой. Учир нь нийт үйл ажиллагаа явуулжбуй аж ахуй нэгжийн тоо 2017 оны хоёрдугаар улирлын байдлаар 75796 байгаа ба үүний 64.0

хувь нь Улаанбаатар хотод, 11.7 хувь нь төвийн бүсэд, 11.0 хувь нь хангайн бүсэд, 9.1 хувь нь баруун бүсэд, 4.2 хувь нь зүүн бүсэд тус тус байршиж байна.







ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

3.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ


3.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2017 оны хоёрдугаар улиралд “ҮЦТХТ” ХХК-д нийтдээ 890,780 данс, 140,165 холболтын данс бүртгэлтэй байна. Нийт дансыг бүтцээр нь үзвэл 886,091 дотоодын иргэн, 1,948 гадаадын иргэн, 2,562 дотоодын аж ахуйн нэгж, 179 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна. Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 4,190 данс шинээр нээгдсэнээс 4,129 нь дотоодын иргэн, 28 нь гадаадын иргэн, 32 нь дотоодын аж ахуйн нэгж, 1

нь гадаадын аж ахуйн нэгжийн данс шинээр бүртгэгдсэн байна.

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хувь 5.3 хувьтай байгаа бол дотоодын аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хувь 94.7 хувьтай байна.

Зураг 26: Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн нийт арилжаанд гадаадын хөрөнгө оруулагчдын эзлэх хувь 2012 оноос буурах хандлага ажиглагдаж эхэлсэн бөгөөд сүүлийн 3 жилд огцом буураад байна. Хөрөнгө оруулагчдын зугтах хандлага манайх шиг хөрөнгийн зах зээлийн хөгжил сул орнуудад мөн адилхан тохиогоод байна¹. Иймд тус орнууд хөрөнгө оруулагч нарын итгэлийг сэргээхэд чиглэсэн бодлого баримталж байгаа ба Монгол Улс “Хөрөнгө

орлуулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл”-ийг 2016 оны 9 дүгээр сард байгуулсан нь энэхүү асуудалд чиглэсэн алхмуудын нэг юм.

Үнэт цаасны зах зээлийн оролцогчид: Тайлант хугацаанд СЗХ-ны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 301 компани бүртгэлтэй байна.

¹ Asian Financial Reform, дугуй ширээний ярилцлага, 2017 он, Япон улс Токио хот.

Хүснэгт 5: Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	Санхүүгийн зохицуулах хороо	"Монголын хөрөнгийн бирж" ХК	"ҮЦТХТ" ХХК
Төрийн өмчит	31	21	35
Төрийн өмчийн оролцоотой	19	16	9
Хувийн өмчит	251	199	273
Нийт	301	236	317

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2013–2016 оны хооронд СЗХ–оос хөрөнгийн биржийн нэр хүндийг өсгөх, үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчлэх, СЗХ–ны бүртгэлийг бүртгэлийн хэлбэрээс зөвшөөрлийн хэлбэрт шилжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд өмч хөрөнгө нь үрэгдсэн, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ сүүлийн 3–аас дээш жилийн хугацаанд тогтмол биелүүлээгүй компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хасах, хууль хяналтын байгууллагуудад шилжүүлэх хийгээд компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.


Ашигт малтмалын тухай хуулийн 5.6–д заасны дагуу 15 стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдийн хувьцааны 10 хувийг хөрөнгийн биржээр арилжаалах хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх нь үнэт цаасны зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг

нэмэгдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог тэлэх ач холбогдолтой бөгөөд дээрх ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдүүдээс нэр бүхий 4 /"Багануур" ХК, "Шивээ овоо" ХК, "Таван толгой" ХК, "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК/ нь хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

3.1.2 ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ


2017 оны 2 дугаар улирлын байдлаар Хөдөө аж ахуйн биржийн гишүүн 15 брокерын компани үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрээс 4 брокер хөдөө орон нутагт байрладаг ба баруун бүсэд 3, зүүн бүсэд 1 брокер тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Харин үлдсэн 11 брокер Улаанбаатар хотод төвлөрөн ажилладаг бөгөөд нийслэлийн нийт 9 дүүргийн 4–т нь брокер, арилжааны зуучлагч /брокер/ – ийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 27: Хөдөө орон нутгууд дахь брокеруудын байршил



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 28: ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөдөө аж ахуйн биржээр дамжин 8 бүтээгдэхүүн арилжигддагаас, тайлант үед нийт 4 төрлийн бүтээгдэхүүн арилжигдсан. Эдгээр нь ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, болон завод ноос (ямааны болон хонины) болно. Бүтээгдэхүүн тус бүрийг арилжигдсан хэмжээгээр нь өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзлээ. Үүнд ямааны ноолуур өмнөх оны мөн үеийнхээс 97.4 тэрбум төгрөг буюу 33 хувиар, завод ноос 1.6 тэрбум төгрөг буюу 111 хувиар тус тус өссөн бол, хонины ноос 1.2 тэрбум төгрөг буюу 65 хувиар, тэмээний ноос 277 сая төгрөг буюу 47 хувиар тус тус буурсан байна.

3.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцох боломжгүй юм. Иймд 2016 оны жилийн эцсийн байдлаар үзүүлээ.

Зураг 29: Даатгалын нягтрал /төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, ҮСХ

2015 оны жилийн эцэст нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 37,261.0 төгрөг байсан бол 2016 оны жилийн эцэст 561.3 төгрөгөөр буюу 1.5 хувиар буурч 36,700.0 төгрөгт хүрэв. Хураамжийн орлогын өсөлт хүн амын өсөлтөөс удаан байсан нь тус бууралтад нөлөөлөв.

Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 2.5 хувиар буурч 35,794.0 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 67.4 хувиар өсөж 905.0 төгрөгт хүрсэн байна.

Даатгалын мэргэжлийн оролцогчдын салбар нэгж: Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын нийт 490 салбар 21 аймаг болон Улаанбаатар хотод байршиж байна. Эдгээр салбарыг бүсээр ангилан харвал төвийн бүсэд хамгийн их буюу 303, хангайн бүсэд 85, баруун бүсэд 57, зүүн бүсэд хамгийн бага буюу 45 салбар нэгж тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 30: Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын салбаруудын байршил /бүсээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд Улаанбаатар хотын нийт дүүрэгт даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компанийн 190 салбар нэгж бүртгэгдэв. Нийт салбар нэгжийн 92 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрсөн байна.

Түүнчлэн даатгалын төлөөлөгчийн газар 11 байгаагаас БНСУ болон БНХАУ-д тус тус нэг төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 31: Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын салбаруудын байршил /дүүргээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.3 БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖ

Бичил санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүдийг газарзүйн байршил, хүйс, насны бүтцээр ангилж үзүүлэх нь санхүүгийн хүртээмжийг илүү дэлгэрэнгүй харуулах ач холбогдолтой. Хүйсээр ангилсан мэдээлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жендерийн ялгааг харуулж, түүнд тулгарч буй саад бэрхшээлд дүн шинжилгээ хийх боломжийг олгодог. Хөгжиж буй орнуудад эмэгтэй хүмүүсийн санхүүгийн оролцоо эрэгтэй хүмүүсийнхээс бага байдаг ба AFI-ийн эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмжийн судалгаагаар санхүүгийн чадавх (75%), барьцааны шаардлага (66%), нийгэм соёлын орчин гэх 3

шалтгаан эмэгтэйчүүдийн санхүүгийн оролцоонд хамгийн их нөлөө үзүүлдэг гэсэн үр дүн гарсан байна. Газарзүйн зураглал нь тодорхой нэг улс орон эсвэл бүс нутгийн санхүүгийн хүртээмжийн ялгааг тодорхойлж тухайн газар бүрд санхүүгийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой. Мөн үзүүлэлтүүдийг насны бүтцээр ангилж харуулах нь бүх насны хүмүүсийн санхүүгийн оролцоог харьцуулах, түүнчлэн хүртээмж бага байгаа насны бүлгийн оролцоог сайжруулах арга хэрэгсэл болно ².

² www.Afi-Global.org


3.3.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

3.3.1.1 ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР АНГИЛСАН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

ББСБ–уудын тархалт: Монгол Улсын 21 аймагт бүгдэд нь ББСБ–ын үйлчилгээ тархсан бөгөөд Говь–Алтай аймагт 2017 оны 2 дугаар улиралд анхны ББСБ тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж эхэллээ. Гэхдээ тооны хувьд

хангалтгүй буюу зөвхөн аймгийн төвүүд дээр цөөн тоогоор үйл ажиллагаа явуулж байна. Харин Улаанбаатар хотын төвийн дүүргүүдэд маш ойрхон байршжээ.

Зураг 32. ББСБ–уудын тархалт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


ББСБ–ын үйлчилгээг хүртэх боломж: Монгол Улсын хэмжээнд 100,000 иргэнд 21, 1000 аж ахуй нэгжид 9

ББСБ ногдож байгаа бол энэ харьцаа Улаанбаатар хотод 40, 12, хөдөө орон нутагт 5, 4 байна.

Зураг 33. ББСБ–ын тоо /аймаг, дүүргээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн үйлчилгээ: 2017 оны 2 дугаар улирлын байдлаар ББСБ-уудаас зээл авсан 65,412 зээлдэгч байгаа ба улсын хэмжээнд зээлдэгч ба хүн амын тооны харьцаа 2 хувь, нэг хүнд ногдож буй зээлийн хэмжээ 176.9 мянган төгрөг байна.

Улаанбаатар хотын хэмжээнд зээлдэгч ба хүн амын тооны харьцаа 4.3 хувь, нэг хүнд ногдож буй зээлийн хэмжээ 380.1 мянган төгрөг байна.

Зураг 34. Зээлдэгчдийн тоо /дүүргээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин аймгуудын хэмжээнд зээлдэгч ба хүн амын тооны харьцаа 0.2 хувь, нэг хүнд ногдож буй зээлийн хэмжээ 9,461.0 төгрөг байна.


ШИГТГЭЭ 2:

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ

Бүгд найрамдах Бурунди улсын банк 2012 онд санхүүгийн хүртээмжийн эрэлт талын судалгаа хийсний үр дүнд эмэгтэйчүүдийн санхүүгийн оролцоо нь эрэгтэйчүүдийнхээс харьцангуй бага байсан ба эмэгтэйчүүдийн санхүүгийн оролцоонд тулгарч буй гол бэрхшээл нь барьцаа хөрөнгийн дутагдал байсан юм. Энэхүү бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд Бурунди улсын банк нь нэмэлт барьцаа хөрөнгө оруулалтын зохицуулалтыг нэвтрүүлсэн байна. Үүний хүрээнд "Loi sur les Sureteis Mobilieres" хэмээх шинэ хуулийг баталж олон төрлийн барьцаа хөрөнгийг ашиглах боломжтой болгожээ.

Эх сурвалж: Afi-Global

Зураг 35. Эзэлдэгчдийн тоо /аймгаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.3.1.2 ХҮЙСЭЭР АНГИЛСАН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Тайлант улиралд 533 ББСБ нийт 1.4 сая харилцагчтай бөгөөд эдгээр нь Монгол Улсын насанд хүрсэн хүн амын 58 хувийг эзэлж байна. Мөн нийт харилцагчдын 55% буюу 749,399 нь эмэгтэй, 45% буюу 603,744 нь эрэгтэй

байна. Доорх зургаас харахад манай улсын эмэгтэй хүмүүсийн санхүүгийн хүртээмж эрэгтэй хүмүүсийнхээс илүү харагдаж байна.

Зураг 36: Харилцагчдын тоо /хүйсээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ШИГТГЭЭ 3:

ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН "БОДИТ" ТОО

Бангладешийн банк нь БЖДҮ-ийн салбарын тоон мэдээллийг цуглуулахдаа дансны өмчлөлийн талаарх мэдээлэл бодит байдлыг илэрхийлдэггүй болохыг олж тогтоосон. Ихэнх тохиолдолд данс нь эмэгтэй хүний нэрээр үүсгэгддэг боловч бизнес нь эрэгтэй хүний хяналтанд байдаг байна. Иймээс Бангладешийн банк нь "Бодит" эмэгтэй бизнес эрхлэгчдийг танихад дэмжлэг үзүүлэх зорилгоор Бангладешийн Эмэгтэйчүүдийн худалдаа, аж үйлдвэрийн танхим (БЭХАҮТ) зэрэг эмэгтэйчүүдийн бизнесийн холбоотой зөвлөлдөж банкуудад удирдамж явуулж тоон өгөгдлийн үнэн зөв байдлыг хангадаг болсон байна.

Эх сурвалж: Afi-Global




3.3.1.3 НАСНЫ БҮТЦЭЭР АНГИЛСАН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Нийт зээлдэгчдийн 40.1% нь 18–35 насныхан, 35.5% нь 36–45 насныхан, 19.1% нь 45–55 насныхан байхад 55–аас дээш насныхан 5.3% байна. Насны бүлгээр харахад 18–

45 насны залуучуудын зээлэх хандлага өндөр болох нь харагдаж байна.

Зураг 37: Зээлдэгчдийн насны бүтэц /тоогоор/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


3.3.2 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

3.3.2.1 ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР АНГИЛСАН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ХЗХ–дын тоо тодорхой хэмжээнд өссөөр байгаа хэдий ч эдгээр тоо нь байршлын хувьд жигд тархсанаар

хүртээмжийг бий болгоно.

Зураг 38: ХЗХ–дын тоо /бус нутгаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ–дын иргэн, аж ахуй нэгжид хүртээмжтэй ажиллах нь чухал үзүүлэлт бөгөөд үүнийг 100 ААН–д ногдох болон 10'000 хүнд ногдох ХЗХ–дын тоогоор илэрхийлж болно.

Улаанбаатар хотод нийт 191 ХЗХ, 7 салбар төлөөлөгчийн хамтаар үйл ажиллагаа эрхэлж байна. Хүртээмжээр 100 ААН–д ногдох үзүүлэлтээр нийслэл хотод Багахангай дүүрэг 2.7, Багануур дүүрэг 1.9 дүнгээр хамгийн сайн байгаа бол Баянгол, Баянзүрх дүүрэг хамгийн бага

үзүүлэлт хэвээр хадгалж үлдсэн байна. Харин 10'000 хүнд ногдох ХЗХ–дын тоо мөн адил Багахангай, Багануур сайн үзүүлэлттэй байна. Багахангай, Багануур дүүргийн ХЗХ–дын тоо бусад дүүргээс харьцангуй бага тоотой байхад хүртээмжийн үзүүлэлт сайн байна. Учир нь тухайн дүүрэгтэй харьцуулагдаж буй ААН болон хүн амын тоо бага байгаатай холбоотой.

Зураг 39: ХЗХ–дын хүртээмжтэй байдал /дүүргээр –Улаанбаатар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Монгол Улсын нийт ХЗХ–дын тоогоор 33 хувийг эзэлж буй аймаг орон нутгийн хүртээмжийг 4 бүсээр ангилж харуулсан бөгөөд нийслэл хотоос илүү жигд тархсан хандлага ажиглагдаж байна. Мөн тайлант улиралд 8

салбар төлөөлөгчийн газар нэмэгдэж орон нутагт нийт 9 салбартай болсон байна. 100 ААН–д ногдох ХЗХ болон 10'000 хүнд ногдох ХЗХ–дын тоогоор баруун, зүүн бүсүүд тус тус хүртээмж сайтай байна.

Зураг 40: ХЗХ–дын хүртээмжтэй байдал /бүсээр–Аймаг орон нутаг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.3.2.2 ХҮЙСЭЭР АНГИЛСАН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант улиралд ХЗХ–дын нийт гишүүд 50,687 өмнөх оны мөн үетэй харьцуулахад гишүүдийн тоо 15.8 хувиар

буюу 6,932 гишүүдээр нэмэгдсэн. Хүйсийн хувьд эмэгтэй гишүүд 56 хувь, эрэгтэй гишүүд 44 хувийг эзэлж байна.

Зураг 41: ХЗХ-дын гишүүд /хүйсийн ангиллаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Гишүүдийн насны бүтцийг 4 бүлгээр ангилсан ба 36–45 насныхан хамгийн их байгаа бол 55–аас дээш насны

интервалд байгаа бүлгийнхэн хамгийн цөөн тооны гишүүд байна.

3.3.2.3 НАСНЫ БҮТЦЭЭР АНГИЛСАН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Зураг 42: ХЗХ-дын гишүүдийн насны бүтэц /интервалаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын тооны өсөлт: Тайлант улиралд өмнөх оны мөн улиралтай харьцуулахад нийт ХЗХ-дын тоо 3.6 хувийн өсөлт үзүүлсэн бөгөөд тухайн оны өмнөх улирлаас 0.2 хувиар өссөн байна. 2014 оноос өмнө ХЗХ-дын тоо орон

нутагт давамгайл байсан бол сүүлийн гурван жилийн хугацаанд нийслэл Улаанбаатар хотын ХЗХ-дын тоо огцом өссөн үүнд нийслэлийн төсөл хөтөлбөрөөр байгуулагдсан ХЗХ-дын тоо шууд нөлөө үзүүлсэн билээ.

Зураг 43: ХЗХ-дын тоо, өсөлтийн хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд нийт 50,687 гишүүнийг аймаг орон нутгийн 4 бүсээр ангилан нэг гишүүнд ногдох хадгаламж болон зээлийн хэмжээ харьцуулахад хангайн бүсэд

хамгийн их буюу 0.8 сая төгрөгийн зээл, 0.7 сая төгрөгийн хадгаламж ногдож байна.

Зураг 44: Нэг гишүүнд ногдох хадгаламж, зээлийн хэмжээ бүсээр /сая төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нэг гишүүнд ногдох хадгаламж зээлийн харьцааг нийслэл Улаанбаатар хотоор харвал Багануур дүүрэгт хамгийн их

буюу 7.4 сая төгрөгийн зээл, 6.5 сая төгрөгийн хадгаламж нэг гишүүнд ногдож байна.

Зураг 45: Нэг гишүүнд ногдох хадгаламж, зээлийн хэмжээ дүүргээр /сая төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо





БҮТЭЭГДЭХҮҮН,
ҮЙЛЧИЛГЭЭ

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ


4.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

4.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаасны зах зээлийн оролцогчид

Тайлант хугацаанд СЗХ–ны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 301 компани бүртгэлтэй үйл ажиллагаа явуулсан.

Зураг 46: Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

СЗХ–ны зүгээс хөрөнгийн биржийн нэр хүндийг өсгөх, үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчлэх, Хорооны бүртгэлийг бүртгэлийн /listing/ хэлбэрээс зөвшөөрлийн /registering/ хэлбэрт шилжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд өмч хөрөнгө нь үрэгдсэн, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хасах, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үнэт цаасны хадгаламж

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 2017 оны 06 дугаар сарын 30–ны өдрийн байдлаар нийт 317 ХК–ийн 1,4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 22,226,429,650 ширхэг үнэт цаас хадгалагдаж байна. Үүнээс:

Нээлттэй ХК–ийн бүртгэлд 312 ХК–ийн 7,011,980,050 ширхэг хувьцаа, үүнээс төрийн өмчтэй 34 ХК–ийн 2,818,123,684 ширхэг хувьцаа, орон нутгийн өмчтэй 9

ХК–ийн 29,045,916 ширхэг хувьцаа, хувийн өмчит 268 ХК–ийн 4,164,810,450 ширхэг хувьцаа байна.

Хаалттай ХК–ийн бүртгэлд 5 ХК–ийн 15,214,449,600 ширхэг хувьцаа хадгалагдаж байгаагаас төрийн өмчийн 1 ХК–ийн /"Эрдэнэс Тавантолгой" ХК/ 12,782,177,319 ширхэг хувьцаа байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017-II
1. Бүртгэлтэй үнэт цаас			
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,809,930	4,160,854	4,164,810
Төрийн мэдлийн хувьцаа	2,246,316	2,818,124	2,818,124
Орон нутгийн оролцоотой	29,046	29,046	29,046
Нийт хувьцаа	5,085,292	7,008,024	7,011,980
Засгийн газрын бонд	2,415	2,808	3,323
Компанийн бонд	283.0	233.0	233.0
Нийт бондын тоо	2,698	3,040	3,556
2. Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас			
Компанийн бонд	20,668	21,870	23,111
Засгийн газрын бонд	2,314	3,725	3,150
Нийт бондын тоо	22,982	25,595	26,261
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	2,558,176	2,212,224	2,212,225
Эрдэнэс Тавантолгой /ААН/	5,139	5,203	5,598
Эрдэнэс Тавантолгой /Төр/	12,436,685	12,782,573	12,782,177
Нийт	15,000,000	15,000,000	15,000,000
Хаалттай ХК	172,753	174,958	214,449,600
Нийт	172,753	174,958	214,449,600

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Төвлөрсөн хадгаламжид төрийн мэдлийн нийт 35 ХК-ийн 15,6 тэрбум ширхэг хувьцаанаас МХБ-д бүртгэлтэй 34 ХК-ийн 2,818,123,684 ширхэг хувьцаа, биржийн бус зах зээлд бүртгэлтэй 1 ХК-ийн /Эрдэнэс Тавантолгой ХК/ 12,782,177,319 ширхэг хувьцаа бүртгэлтэй байна.

Нийт 29 төрлийн 25,644,183 ширхэг компанийн бонд, 172 төрлийн 10,820,020 ширхэг Засгийн газрын бонд бүртгэлтэй байна. Үүнээс 24 төрлийн 25,351,219 ширхэг хөрөнгөөр баталгаажсан бонд, 92 төрлийн 4,336,500 ширхэг Засгийн газрын бонд нь биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт: 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 13 ХК-тай ногдол ашгийн гэрээ байгуулж, үйлчилгээний хөлс 2,294,600 төгрөг тооцож нийт 16,253 харилцагчийн дансанд 9,7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг байршуулсан.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид: Тайлант хугацаанд 61 ҮЦК Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 14 компани үйл ажиллагаа явуулж байгаа бол Хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 15 этгээд тусгай зөвшөөрөлтэй байна. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 7: Зохицуулалттай этгээдийн тоо

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	14
5	Брокер, дилер	61
6	Кастодиан банк	3
7	Андеррайтер /давхардсан тоогоор/	22
8	Хөрөнгө оруулалтын зөвлөх /давхардсан тоогоор/	15
	НИЙТ	82
9	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
10	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	15
11	Аудитын компани	44
12	Үнэлгээний компани	20
13	Хуулийн компани	19

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.1.2 ХАА-Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

2013 оны 4 дүгээр сард биржээр дамжин зөвхөн нэг төрлийн түүхий эд буюу ямааны ноолуур арилжаалагддаг байсан бол 2017 оны 2 дугаар улирлын байдлаар бараа бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж 8 төрлийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалагддаг болсон байна. Үүнд: ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр, хүнсний буудай болон тосны ургамал зэрэг багтдаг. Завод ноос нь адууны, хонины, ямааны, сарлагийн, тэмээний гэж 5 ангилагддаг бол бодын хөөвөр нь сарлагийн, адууны, үхрийн гэсэн 3 ангилалд хуваагддаг.

2017 оны 2 дугаар улирлын байдлаар эдгээр 8 төрлийн түүхий эдээс нийт 4 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан ба тэдгээр нь ямааны ноолуур, хонины ноос, тэмээний, болон завод ноос болно. Үүнд, завод ноосноос зөвхөн ямааны болон хонины завод ноос арилжаалагдсан байна.

2017 оны 2 дугаар улиралд арилжигдсан барааны хэмжээгээрээ ямааны ноолуур хамгийн их буюу 4934 тонн арилжаалагдаж, харин тэмээний ноос хамгийн бага буюу 52 тонн арилжаалагдсан байна. Харин арилжааныхаа дүнгээр мөн ямааны ноолуур 389.3 тэрбум төгрөг буюу нийт арилжааны 98.9 хувийг эзэлсэн бол тэмээний ноос 312.2 сая төгрөг буюу нийт арилжааны 1 хүрэхгүй хувийг эзэлсэн байна.

Хүснэгт 8: 2017 оны 1 улирлын ХАА-н биржийн арилжааны хэмжээ, дүн

Д/д	Барааны нэр	Барааны хэмжээ /тонн/	Арилжааны дүн /тэрбум төгрөг/	Эзлэх хувь /арилжааны дүнгээр/
1	Ямааны ноолуур	4,934	389	98.98
2	Хонины ноос	486	0.639	0.16
3	Тэмээний ноос	52	0.312	0.08
4	Завод ноос			
4.1	Ямааны завод ноос	151	2.2	0.2
4.2	Хонины завод ноос	613	0.792	0.58
	Нийт	6,237	393.4	100

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээл дээр ердийн, урт хугацааны болон давхар даатгалын нийт 24 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн арилжаалагдаж байна. Жолоочийн хариуцлагын, албан журмын даатгалаас бусад бүх хэлбэрийн даатгал нь сайн дурын үндсэн дээр хийгдэж байгаа билээ.

Тайлант хугацаанд даатгалын зах зээлийн хэмжээнд нийт 85.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласнаас ердийн даатгал 83.8 тэрбум төгрөг буюу нийт зээлийн 97.6 хувь, урт хугацааны даатгал 736.7 сая төгрөг буюу 0.9 хувь, давхар даатгал 1 тэрбум төгрөг буюу 1.2 хувийг бүрдүүлэв. Харин нийт нөхөн төлбөрийн зардалд ердийн даатгал 16.6 тэрбум төгрөг буюу 96.2 хувь, урт хугацааны даатгал 664.5 сая төгрөг буюу 3.8 хувийг эзэлж байна.

Даатгалын нийт хураамжийн орлогын бүтцэд хөрөнгийн даатгал 28.6 хувь, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 21.5 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 11 хувь, гэнэтийн осол эмчилгээний даатгал 10.1 хувь, агаарын хөлгийг эмчлэх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал 7.7 хувь, барилга угсралтын даатгал


7.3 хувь, хариуцлагын даатгал 5.9 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 5.9 хувийг бусад ердийн даатгалын хэлбэрүүд, 0.9 хувийг урт хугацааны даатгал, 1.2 хувийг хөдөө аж ахуйн давхар даатгал тус тус эзэлж байна.

Даатгалын нийт нөхөн төлбөрийн бүтцэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 45.7 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 21.6 хувь, гэнэтийн осол эмчилгээний даатгал 12.5 хувь, санхүүгийн даатгал 6.6 хувь, хөрөнгийн даатгал 6.3 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 3.4 хувийг бусад ердийн даатгалын хэлбэрүүд, 3.8 хувийг урт хугацааны даатгал тус тус эзэлж байна.

Албан журмын даатгал: Жолоочийн хариуцлагын даатгал нь 2012 оноос хойш албан журмын даатгал болсон билээ.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого 2016 оны хоёр дугаар улирлаас 10.1 хувиар буюу 1.85 тэрбум төгрөгөөр өссөн бол нөхөн төлбөр 7.2 хувиар буюу 0.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. 2016 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт хураамжийн орлогын 44.3 хувь нь нөхөн төлбөрт зарцуулагддаг байсан бол 2017 оны хоёрдугаар улирлын байдлаар 43 хувь болж буурсан байна.

Зураг 47: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын зуучлагчид: Энэ оны эхний хагас жилд тусгай зөвшөөрөл авсан 40 даатгалын зуучлагчид бүртгэгдээд байгаа бөгөөд нийт 16.2 тэрбум төгрөгийн зуучилсан даатгалын хураамжийн орлоготой ажиллав. Үүнээс 11 тэрбум төгрөг буюу нийт зуучилсан даатгалын

хураамжийн орлогын 68.2 хувийг даатгалын зуучлагч банкууд бүрдүүлэв. Зуучлагч компаниуд тайлант хугацаанд 3 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлоготой ажилласан байна.

Зураг 48: Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого /бүтээгдэхүүнээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын зуучлалын шимтгэлийн орлогод жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 36.2 хувь, зээлийн даатгал 20.4 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 14.1 хувь, хөрөнгийн даатгал 13.4 хувь, мал амьтдын даатгал 7.8 хувь, бусад даатгалын хэлбэрүүд 8.1 хувийг тус тус эзлэв.

Даатгалын төлөөлөгч: Даатгалын төлөөлөгчөөр дамжин орсон хураамжийн орлогод жолоочийн хариуцлагын даатгал 35.9 хувь, хөрөнгийн даатгал 22.2 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 19.7 хувь, хариуцлагын даатгал 5.9 хувь, гэнэтийн осол, эмчилгээний даатгал 11.1 хувь, санхүүгийн даатгал 3 хувь, бусад даатгалын хэлбэрүүд 2.8 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 49: Даатгалын төлөөлөгчөөр дамжиж орсон хураамжийн орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын хохирол үнэлэгчид: 2017 оны эхний хагас жилд даатгалын хохирол үнэлэгчид 7 тэрбум төгрөгийн хохирол үнэлж, 357.5 сая төгрөгийн хохирол үнэлгээний орлоготой ажиллав.

Даатгалын хохирол үнэлгээний орлогод жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 60.4 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 19.1 хувь, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 10.8 хувь, хөрөнгийн даатгал 8.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 50: Даатгалын хохирол үнэлгээний орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд зааснаар Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй ББСБ-ууд зээл, төлбөрийн баталгаа гаргах, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, факторингийн үйлчилгээ, үл хөдлөх эд хөрөнгө

барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа гэсэн үндсэн 10 үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж байна. Эдгээр үйл ажиллагаанаас зээлийн үйлчилгээг нийт ББСБ-ын 90% буюу 480 ББСБ, гадаад валютын арилжааг 27.4% буюу 147 ББСБ үзүүлдэг байгаа ба одоогоор үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг нэг ч ББСБ аваагүй байна.

Зураг 51: Үйл ажиллагааны төрөл /давхардсан тоогоор/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-ууд 2 дугаар улиралд 89.4 тэрбум төгрөгийн орлого олсноос 86.3 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос олжээ. Тайлант улиралд зээлийн хүүгийн

орлого хамгийн өндөр буюу 88 хувийг зээлж байгаа бол шинээр нэмэгдсэн үйлчилгээний орлого болох картын үйлчилгээний орлого энэ улиралд бүртгэгдээгүй байна.

Зураг 52: ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого/тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

*-Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах зуучлалын үйлчилгээ үзүүлсэн тул төлбөр тооцооны хэрэгслийн орлогоос хасаж шимтгэл, хураамжийн орлогод бүртгэв.

ШИГТГЭЭ 4:

БЖДҮ-ИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХҮРТЭЭМЖ

БЖДҮ-үүд нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур бөгөөд уул уурхайгаас бусад салбарт төвлөрсөн байдаг. Монгол улсын бичил, жижиг, дунд үйлдвэрүүд нь ДНБ-ий 25 хувийг үйлдвэрлэж, баялаг бүтээгч салбаруудад хөдөлмөр эрхлэлтийн 52 хувийг бүрдүүлдэг байна. Эдийн засгийн энэхүү чухал салбарыг дэмжиж, өргөжүүлэх нь уул уурхайн экспортоос шууд хамааралтай эдийн засгийг төрөлжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Ялангуяа БЖДҮ-үүдэд тулгамдаж буй гол бэрхшээл нь шаардлагатай санхүүжилт болохыг судалгаа харуулсан.

БЖДҮ-үүдийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулахад 5 гол сорилт тулгамдаж байна. Үүнд: (i) БЖДҮ-үүдэд чиглэсэн чанартай бодлого боловсруулахад статистик мэдээлэл хомс, (ii) зээлийн одоогийн бүтээгдэхүүнүүд БЖДҮ-үүдийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй, (iii) барьцаа хөрөнгийн хатуу шаардлага, (iv) зээл авах үйл явц удаашралтай, (v) санхүүгийн мэдлэг боловсрол дутмаг зэрэг болно.

ЭЗХАХБ-ын төслийн зөвлөхүүд Монгол улсад томиллолтоор ажиллах явцад тус улсын төр ба хувийн хэвшлийн оролцогч талуудтай уулзалт, хэлэлцүүлэг хийсний үр дүнд БЖДҮ-үүдийн санхүүжилтийн хэрэгцээг хангах 5 гол гарцыг тодорхойлсон. Үүнд:

- 1. БЖДҮ-ийн статистик мэдээний чанарыг сайжруулах:** ЭЗХАХБ-ын ЖДҮ-ийн Санхүүгийн мэдээллийн сан болон бизнесийн санхүүжилтийн мэдээлэлтэй нийцүүлснээр найдвартай, логик уялдаатай статистик бүрдүүлэх боломжтой. Одоогоор олон байгууллага харилцан адилгүй тодорхойлолт бүхий статистик мэдээ, үзүүлэлтүүдийг өөр өөр арга замаар бүрдүүлж ашигладаг. ЖДҮ-ийн тодорхойлолтууд болон статистик мэдээг зохистой уялдуулж жигдлэх нь бодит дүн шинжилгээ, нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад дөхөм болно.
- 2. ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн төрөл, хамрах хүрээг сайжруулах:** БЖДҮ-үүдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, өртөг зардал бага зээл авах нөхцлийг бүрдүүлэн, ялангуяа зээлийн хүүг багасгах, хугацааг уртасгах замаар одоогийн зээлийн бүтээгдэхүүнүүд болон БЖДҮ-үүдийн эрэлт хэрэгцээний зөрүүтэй байдлыг багасгах боломжтой.

3. **Зээлийн батлан даалтын сангийн эрсдэлийн үнэлгээний арга техник болон үйл ажиллагааны найдвартай байдлыг бэхжүүлэх:** замаар өндөр үнэлгээтэй барьцаа хөрөнгийн хатуу шаардлагыг багасгах боломжтой. Одоогоор БЖДҮ-үүдээс зээлийн дүнгийн 200%-тай тэнцэхүйц үнэлгээтэй барьцаа хөрөнгийг шаарддаг.
4. **БЖДҮ-үүдэд зориулж Нэг-цонхны үйлчилгээ байгуулж, ЖДҮХС болон банкуудын үйл ажиллагааг уялдуулах:** замаар БЖДҮ-үүдийн зээлийн хүртээмжийг хялбаршуулах боломжтой. БЖДҮ-үүд зээл авахын тулд төрийн захиргааны 6 байгууллагад очих, 25-30 албан баримт бичиг бүрдүүлэх шаардлагатай одоогийн нүсэр, удаашралтай үйл явцыг хялбаршуулж хөнгөвчлөх хэрэгтэй.
5. **Санхүүгийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх:** ЭЗХАХБ-ын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээнд нэгдэх, "Олон нийтийн санхүүгийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-т БЖДҮ-үүдэд чиглэсэн үйл ажиллагаа, арга хэрэгслүүдийг тусгах замаар БЖДҮ-үүдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хэрэгтэй. БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн баримт бичгүүдийн чанар дээшлэхээс гадна банкуудын санал болгож буй зээл/санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг харьцуулах чадвартай болно. Энэ нь банкны салбарт өрсөлдөөнийг идэвхжүүлнэ.


Эх сурвалж: OECD.ORG/Eurasia-week

4.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс олсон орлого: Тайлант улиралд 287 ХЗХ-дын нийт хүүгийн орлого 13.3 тэрбум төгрөгт хүрч үүнээс хамгийн их хувийг эзэлж буй зээлийн хүү 95.6 хувь буюу 12.7 тэрбум төгрөгийн орлого

оруулсан байна. Харин бусад орлогын нийлбэр 632.2 сая төгрөг гарч, зээлийн хүүгийн орлогын буцаалт 45.9 сая төгрөг болсон байна.

Зураг 53: ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс олсон орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс гарсан зардал: Тайлант улиралд нийт хүүгийн зардал 7.3 тэрбум төгрөг байна. Үүнээс хадгаламжийн хүүгийн зардал 97.1 хувийг

эзлэх бөгөөд бусад зардлын нийлбэр 209.7 сая төгрөг бол хүүгийн зардлын буцаалт 2.3 сая төгрөг байна.

Зураг 54: ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс гарсан зардал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ШИГТГЭЭ 5:

СЗХ ICURN – ЫН ГИШҮҮН БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хороо нь 2017 оны 7 дугаар сард ICURN-ын гишүүн болсон бөгөөд Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны зохицуулагчдын хурал /ICURN/-д оролцлоо.

Олон улсын ХЗХ-дын зохицуулагчдын сүлжээ буюу ICURN нь санхүүгийн хоршоодын хянан шалгагчдын албан бус сүлжээ хэлбэрээр 2007 онд үүссэн ба 2015 онд удирдах зөвлөлөөс нь бие даасан нэгж болгохоор шийдвэрлэж АНУ-д бүртгэлтэй татвараас чөлөөлөгдсөн, ашгийн бус холбооны статустай байгууллага юм.

Жижиг хэмжээний хадгаламж татдаг олон тооны хоршоодыг хянахад хянан шалгагчдад учирдаг нийтлэг бэрхшээлийг давахад туслах, хянан шалгагчид хооронд мэдээлэл солилцох, сайн туршлага судлах боломжоор хангах, сургалтын болон мэдээллийн мэргэжлийн холбоо болох зорилготой тус байгууллагад зургаан тивийн төлөөлөл болсон 34 орон гишүүнчлэгдээд байна. Энэ удаагийн хурлын үеэр Монгол, Малави, Шинэ Брунсвик улсуудын зохицуулагч байгууллагууд шинээр гишүүнээр элслээ.


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо




ИНФОГРАФИК

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын салбарын нийт хөрөнгө /Тэрбум төгрөг/



Даатгалын нөөц сан /Тэрбум төгрөг/




Нийт хураамжийн орлого /Тэрбум төгрөг/

Year	Total Dividend Income (TBD)	Shareholder Dividend Income (MnTD)	Dividend Yield (%)
2017.II	85.54	*	1.18%
2016.II	61.10	36700	0.55%
2015.II	66.78	37261	0.61%
2014.II	57.07	36298	0.55%
2013.II	42.43	32051	0.49%
2012.II	41.87	27465	0.54%


Нийт нөхөн төлбөр /Тэрбум төгрөг/



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ОРОЛЦОГЧИД




ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС




2017 оны II улиралын байдлаар Монголын Ипотекийн корпораци 2.98 их наяд төгрөгийн орон сууцаар баталгаажсан үнэт цаас гаргаад байна. Хөтөлбөрийн хүрээнд 49052 хүн орон сууцны хөнгөлөлттэй зээлдэд хамрагдсан байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА


Банк бус санхүүгийн байгууллагын тоо




Харилцагчдын тоо /Мянгаар/



Нийт хөрөнгө /Тэрбум төгрөг/




Нийт зээл /Тэрбум төгрөг/




ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО


Хадгаламж, зээлийн хоршоодын тоо




Хадгаламж, зээлийн хоршоодын гишүүд /Мянгаар/



/Тэрбум төгрөг/





V

АШИГТ

АЖИЛЛАГАА

АШИГТ АЖИЛЛАГАА

5.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

5.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Мэргэжлийн зуучлагч ҮЦК¹-уудын өнөөгийн нөхцөл байдал: 2017 оны эхний хагас жилийн байдлаар СЗХ-ны тайлан

тэнцлийн цахим системд тайлангаа ирүүлсэн ҮЦК-уудын нэгтгэлийг хураангуй байдлаар хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 9: Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлант үе
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	73.6
2	Эргэлтийн бус хөрөнгө	21.7
3	Нийт актив	95.3
4	Өр төлбөр	21.2
5	Эздийн өмч	69.8
6	Нийт пассив	95.3

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын нэгтгэлд хамрагдсан нийт ҮЦК-уудын нийт актив тайлант үеийн байдлаар 95.28 тэрбум төгрөг байгаагаас 77.26 хувийг эргэлтийн хөрөнгө, 22.74 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлжээ. Нийт пассивын 16.04 хувийг өр төлбөр, 73.26 хувийг эздийн өмч тус тус эзэлсэн бөгөөд үүнээс богино хугацаат өр төлбөр 84.8

хувийг, урт хугацаат өр төлбөр 8.05 хувийг, урт хугацаат зээл 7.1 хувийг тус тус эзэлжээ.

Эздийн өмчийн хувьд нийт пассивын 73.26 хувийг, үүнээс нэмж төлөгдсөн капитал 12.7 хувийг, сангууд 0.05 хувийг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 5.7 хувийг, эздийн өмчийн бусад хэсэг 2.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: Нийт орлого /тэрбум төгрөгөөр/

№	Орлогын хураангуй тайлан	Тайлант үе
1	Үйл ажиллагааны орлого	2.6
2	Ногдол ашгийн орлого	0.8
3	Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	2.9
4	Ажиллагсадын цалингийн зардал	0.5
5	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	0.3
6	Санхүүгийн зардал	0.4
7	Бусад зардал	0.01
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(0.2)
9	Бусад ашиг (алдагдал)	0.7
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1.3
11	Орлогын татварын зардал	0.1
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1.2

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

1 ҮЦК – брокер, дилер, андеррайтер

Тайлант хугацаанд салбарын нэгтгэлд хамрагдсан нийт 40 ҮЦК-уудаас 29 үнэт цаасны компани алдагдалтай, 11 үнэт цаасны компани ашигтай ажилласан байна. Алдагдалтай ажилласан үнэт цаасны компаниудаас нэр бүхий 5 ҮЦК үнэт цаасны арилжаанд оролцоогүй, шимтгэлийн орлого олоогүй, түрээсийн болон ашиглалтын зардал зэрэг тогтмол шинжтэй үйл ажиллагааны зардлуудаас хамааран алдагдал хүлээсэн. Мөн нийт зардлын хувьд үндсэн үйл ажиллагааны зардлууд болох ажилчдын зардал, төлбөр, хураамжийн зардал, санхүүгийн зардал, түрээсийн зардлууд өндөр хувьтай байгаа нь ашиг буурахад голлох нөлөөг үзүүлж байна.

Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт

2017 оны хоёрдугаар улиралд нийт 125 удаагийн арилжаагаар 112 компанийн 45.5 сая ширхэг хувьцааг 12.2 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаагаар 4.7 сая ширхэг үнэт цаасыг 433.9 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 620.0 мянган ширхэг үнэт цаасыг 60.1 тэрбум төгрөгөөр, компанийн өрийн хэрэгслийн арилжаагаар 60.0 мянган ширхэг бондыг 6.0 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 512.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна.

Нийт арилжааны үнийн дүнгийн 2.4 хувь буюу 12.2


тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 84.7 хувь буюу 433.9 тэрбум төгрөгийг ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа, 11.7 хувь буюу 60.1 тэрбум төгрөгийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа, 1.2 хувь буюу 6.0 тэрбум төгрөгийг компанийн өрийн хэрэгслийн арилжаа тус тус эзэлж байна.

Хувьцааны арилжаа

2017 оны хоёрдугаар улиралд нийт 125 удаагийн арилжаагаар 112 компанийн 45.5 сая ширхэг хувьцааг 12.2 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаагаар 4.7 сая ширхэг үнэт цаасыг 433.9 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 620.0 мянган ширхэг үнэт цаасыг 60.1 тэрбум төгрөгөөр, компанийн өрийн хэрэгслийн арилжаагаар 60.0 мянган ширхэг бондыг 6.0 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 512.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн.

Нийт арилжааны үнийн дүнгийн 2.4 хувь буюу 12.2 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 84.7 хувь буюу 433.9 тэрбум төгрөгийг ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа, 11.7 хувь буюу 60.1 тэрбум төгрөгийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа, 1.2 хувь буюу 6.0 тэрбум төгрөгийг компанийн өрийн хэрэгслийн арилжаа тус тус эзэлж байна.

Зураг 55: Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хувьцааны тендер саналын арилжаа

Тайлант хугацаанд “Монгол даатгал” ХХК нь Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 57.1, “ҮЦЗЗ тухай хууль”-ийн 22.1.1 болон СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны тухай журам”-ыг үндэслэн “Хорго хайрхан” ХК-ийн хувьцааг үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр худалдан авах санал гаргаж, тус саналын арилжаагаар нийт 109.9 мянган ширхэг хувьцааг 30.0 сая төгрөгөөр арилжсан байна.

Хорооны зүгээс үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, өөрийгөө зохицуулах байгууллагын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор үнэт цаасны бүртгэлийн журамд зохицуулалтын өөрчлөлт хийснээр СЗХ болон Хөрөнгийн биржийн чиг үүргийн давхардлыг бууруулж, компаниуд хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлж, урт хугацааны санхүүжилтийг татах орчныг улам хялбаршуулсан алхам болоод байна.

Зураг 56: Шинээр IPO, SPO хийсэн компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа

Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа 24 удаа явагдаж, 12, 28, 39, 52, 104, 156 долоо хоногийн хугацаатай нийт 4.7 сая ширхэг үнэт цаасыг 433.9 тэрбум төгрөгөөр арилжаад байна. ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлд 620.0 мянган ширхэг үнэт цаасыг 60.1 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд СЗХ-ны 2017 оны 75 дугаар тогтоолоор "МИК Актив арван хоёр" ХХК-ийн 262,445 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгээд байна. 2017 оны 2 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр 12 удаагийн үнэт цаасжуулалт хийгдсэнээс нийт 403,8 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөгдсөн байна.

Хүснэгт 11: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөгөөр/

ХБҮЦ гаргагч	Нийт гаргасан үнэт цаас (Хорооны тогтоолоор)	"ҮЦТХТ" ХХК-д бүртгэгдсэн	Төлөгдсөн үндсэн төлбөрийн дүн	Зээлдэгчийн тоо (эхний үлдэгдэл)	Зээлдэгчийн тоо (2017 II үлдэгдлээр)
"МИК активнэг ТЗК" ХХК	328.1	322.9	99.1	7853	6162
"МИК активхоёр ТЗК" ХХК	224.8	222.1	50.8	5898	4,909
"МИК активгурав ТЗК" ХХК	328.5	324.6	60.6	7059	6,237
"МИК активдөрөв ТЗК" ХХК	459.4	452.3	73.2	9961	8,991
"МИК активтав ТЗК" ХХК	301.2	294.3	39.7	5997	5,585
"МИК активзургаа ТЗК" ХХК	267.8	261.7	29.5	5277	5,009
"МИК активдолоо ТЗК" ХХК	299.6	293.8	28.1	5453	5,258
"МИК актив найм ТЗК" ХХК	189.8	186.3	14.2	3311	3,189
"МИК актив ес ТЗК" ХХК	137.5	106.1	6.2	1726	1,684
"МИК актив арав ТЗК" ХХК	103.0	96.3	1.3	1532	1,521
"МИК актив арваннэгТЗК" ХХК	70.9	67.5	1.1	1110	1,098
"МИК актив арванхоёр ТЗК" ХХК	272.3	262.4	0	4327	4,318
НИЙТ	2982,9	2890,3	403,8	59,504	49,052

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

"МИК ОССК" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах хүрээнд тусгай зориулалтын компаниудыг үүсгэн байгуулж, СЗХ-оос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах зөвшөөрөл авсан бөгөөд 2015 онд "МИК ОССК"

ХХК нь олон нийтэд 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,709,320 ширхэг үнэт цаасыг санал болгож, нээлттэй ХК болсон. ХБҮЦ-ны 90 хувийг Монголбанк, үлдсэн 10 хувийг ипотекийн зээлийн багц хөрөнгөө худалдсан банкууд зээмшиж байна.

Үнэт цаасны зах зээлийн эрэлт талын хүчин зүйлс


“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 893,646 данс, 14,082 холболтын данс нээгдсэн байна.

Нийт дансыг бүтцээр нь үзвэл, 888,879 дотоодын иргэн, 1,994 гадаадын иргэн, 2,591 дотоодын аж ахуйн нэгж, 182

гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна.

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хувь 2.4 хувьтай байгаа бол дотоодын аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хувь 97.6 хувьтай байна.

Зураг 57: Гадаад хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Үнэт цаасны арилжааны мөнгөн гүйлгээ

2017 оны эхний хагас жилд “МХБ” ХК-ийн 24 удаагийн арилжаагаар 1,222-1,258 код бүхий 37 төрлийн 433,896,834,204.00 төгрөгийн үнэ бүхий 4,696,035 ширхэг Засгийн газрын үнэт цаас, 1 удаагийн арилжаагаар 3015 код бүхий Сүү ХК-ийн гаргасан 6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 60,000 ширхэг компанийн бонд арилжигдсаны төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хийгдсэн арилжааны мөнгөн төлбөрийн тооцоог арилжааны 4 банкаар дамжуулан банк хооронд нийт 12,131.0 сая төгрөгийн тооцоо гүйцэтгэсэн байна. Үүнд: Голомт банкаар 2,765.3 сая төгрөг, ХХБ-аар 3.8 тэрбум төгрөг, Хас банкаар 3.8 тэрбум төгрөг, ХААН банкаар 1.7 тэрбум төгрөгийн гүйлгээ тус тус хийсэн байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 317 ХК-ийн 1.4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 22.2 тэрбум ширхэг үнэт цаас хадгалагдаж байна. Үүнээс:

Нээлттэй ХК-ийн бүртгэлд 312 ХК-ийн 7,011,980,050 ширхэг хувьцаа, үүнээс төрийн өмчтэй 34 ХК-ийн 2,818,123,684 ширхэг хувьцаа, орон нутгийн өмчтэй 9

ХК-ийн 29,045,916 ширхэг хувьцаа, хувийн өмчит 268 ХК-ийн 4,164,810,450 ширхэг хувьцаа байна.

Хаалттай ХК-ийн бүртгэлд 5 ХК-ийн 15.2 тэрбум ширхэг хувьцаа хадгалагдаж байгаагаас төрийн өмчийн 1 ХК-ийн /“Эрдэнэс Тавантолгой” ХК/ 12.8 тэрбум ширхэг хувьцаа байна.

Өнөөгийн үнэт цаасны зах зээлийн дэд бүтцэд дундын зуучлалын /ССР/ тогтолцоо үүсэн бий болох шатандаа хөгжиж байгаа, мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн болон хүний нөөцийн чадавх сул байгаагаас зах зээлд үнэт цаас зээлээр худалдах, худалдан авах, барьцааны удирдлага, үүсмэл хэрэгсэл бий болоход бэрхшээл тулгараад байна.


Цаашид нэгэнт зах зээлд үүсэн бий болсон 3 биржийн төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг уялдуулах, тооцооны үйл ажиллагааг нэгдсэн тооцооны төвөөр гүйцэтгүүлэх, биржүүдийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч, харилцагчдад олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэг дороос өртөг багатайгаар хүргэх ажлуудыг бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх чиглэлээр Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуйн яам, биржүүдийн удирдлагуудтай хамтран ажиллах нь зүйтэй.

5.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Тайлант улиралд даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 тэрбум төгрөгөөр буюу 57.9 хувиар өсөж, 6.9 тэрбум төгрөгт хүрэв. Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл хасах өсөлттэй буюу цэвэр ашгийн хэмжээ буурсан 6 даатгалын компани, 0%–50%–ийн өсөлттэй 3 даатгалын компани,

50%–100%–ийн өсөлттэй 2 даатгалын компани, 100%–аас дээш өсөлттэй 6 даатгалын компани байна. Ердийн даатгалын компаниудын татварын дараах цэвэр ашгийн хэмжээ дунджаар 3.5 дахин өсжээ.

Зураг 58: Цэвэр ашиг



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хувьд өмнөх онтой харьцуулахад татварын дараах цэвэр ашгийн хэмжээ 2.5 дахин буюу абсолют дүнгээр 1.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарчээ. Харин урт хугацааны даатгалын компанийн ашгийн үзүүлэлт энэ оны эхний хагас жилд 40 хувийн буюу 31.2 сая төгрөгийн өсөлттэй байлаа.

Голлох харьцаанууд: Хохирол нөхөлтийн харьцаа тайлант улиралд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байв. Энэ нь нийт нөхөн төлбөрийн зардал 6.8 хувиар, орлогод тооцсон хураамж 11.7 хувиар өссөнтэй, өөрөөр хэлбэл орлогод тооцсон хураамжийн өсөлт нөхөн төлбөрийн зардлын өсөлтөөс илүү өндөр байсантай холбоотой юм.


Сүүлийн жилүүдэд даатгагчид үйл ажиллагааны зардлыг хамгийн оновчтой түвшинд хүргэхийг зорих болсон нь зардлын харьцааг сайжрахад түлхэц өгч байна. 2008 оны эхний хагас жилтэй харьцуулахад зардлын харьцаа

79 хувиас 53.7 хувь болж буурчээ. Даатгалын компаниуд зардлын удирдлагаа сайжруулан, өсөлтийг дэмжих шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлснээр энэхүү харьцааг цаашид ч бууруулах боломжтой юм.

Салбарын хэмжээнд зардлын хосолсон харьцааг авч үзвэл нөхөн төлбөр болон үйл ажиллагааны зардал нийт орлогод тооцсон хураамжийн орлогын 98.4 хувьтай тэнцэж байна. Зардлын хосолсон харьцаа 2014 оноос 2016 онуудад 100 хувиас дээш үзүүлэлттэй буюу даатгалын бус орлогоос дээрх зардлуудыг нөхөж байсан бол энэ оны эхний хагас жилд орлогод тооцсон хураамж нь зардлаа санхүүжүүлэхэд хүрэлцээтэй ба 100 хувиас доош үзүүлэлттэй байв.

Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант хугацаанд өссөн үзүүлэлттэй байлаа. 2016 оны хоёрдугаар улиралд цэвэр ахиуц ашиг 7.2 хувьтай байсан бол 2017 оны мөн үед 8.2 хувь байна.

Зураг 59: Цэвэр ахиу, хосолсон харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ашигт ажиллагааны коэффициент: Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2009 оны хоёрдугаар улиралд хамгийн өндөр буюу 15.32 хувь байсан бол 2014 онд уг үзүүлэлт буурч 2.2 хувьд хүрсэн билээ. 2014 оноос хойш өөрийн хөрөнгийн өгөөжийн харьцаа өсөх хандлагатай байгаа ба тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 2 хувиар өсөж 6.5 хувьд хүрэв.

Нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийн графикайн чиглэлд ижил төлөв ажиглагдаж байна. 2014 онд нийт хөрөнгийн өгөөж хамгийн доод цэгтээ буюу 1.02 хувьд хүрсэн боловч дараах жилүүдэд сэргэж эхэлсэн. Тайлант хугацаанд нийт хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар өсөж 2.95 хувьтай байна.

Зураг 60: Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

5.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-уудын ашиг өнгөрсөн оны мөн үеэс 3.1 тэрбум төгрөгөөр буюу 12.4 хувиар өсөж, 28.1 тэрбум төгрөгт хүрлээ.

Хүснэгт 12: Ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/


№	Үзүүлэлт	2016-II	2017-II	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
1	Нийт орлого	84.2	89.5	5.3	6.3
2	Нийт зарлага	59.2	61.4	2.2	3.7
	ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	25.0	28.1	3.1	12.4

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын хэмжээнд нийт 533 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 76.7 хувь буюу 409 ББСБ 32.4 тэрбум төгрөгийн ашигтай, 5.1 хувь буюу 27 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 18.2 хувь буюу 97 ББСБ 4.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Сүүлийн 5 жилийн дүн мэдээнээс харахад ББСБ-уудын ашигт ажиллагааны үзүүлэлт 2013 онд өмнөх оны мөн үеэс 56.6 хувиар өсөөд байсан бол 2014 оноос эхлэн өсөлтийн хурдац нь саарсаар 2017 оны тайлант улиралд 12.4 хувьд хүрсэн байна.

Зураг 61: Ашигт ажиллагаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-ын салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж 3.7 хувь, эзэмшигчдийн өмчийн өгөөж 4.7 хувь байгаа ба 2012 оны 1 дүгээр улирлаас өсөж эхэлсэн нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж тайлант улиралд өмнөх

оны мөн үеэс 1 болон 0.4 хувиар тус тус буурлаа. Гэвч зах зээлд ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тоо нэмэгдсээр байна.

Зураг 62: Хөрөнгийн өгөөж




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ бүрийн хөрөнгийн өгөөжийг тооцоход нийт ББСБ-ын 1 хувь нь 21 хувиас дээш, 11 хувь нь 11–21 хувь хүртэлх, 47 хувь нь 1–11 хувь хүртэлх, 15 хувь нь 0.1–

1 хувь хүртэлх, 25 хувь нь 0.1 хувиас доош өгөөжтэй ажилласан байна.

Зураг 63: ББСБ тус бүрийн хөрөнгийн өгөөж




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

400 саяас 800 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-уудын нийт хөрөнгийн өгөөж бусад ББСБ-уудаас бага байгаа ба өөрийн хөрөнгийн өгөөж нь нийт хөрөнгийн өгөөжөөс их байна. 1 тэрбумаас дээш хувь нийлүүлсэн

хөрөнгөтэй ББСБ-уудын өөрийн хөрөнгийн өгөөж нийт хөрөнгийн өгөөжөөс давсан нь өөрийн санхүүжилтээр хөшүүрэгдсэнтэй холбоотой байж болох юм.

Зураг 64: ББСБ-уудын өгөөжийн дундаж түвшин




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

5.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-дын үр ашигт байдал: Тайлант улиралд 287 ХЗХ-дын нийт ашиг 1.6 тэрбум төгрөг гарч нийт орлого өмнөх

оны мөн улирлаас 18 хувиар өссөн бол нийт зарлага 21 хувиар өссөн байна.

Зураг 65: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд 186 ХЗХ 2 тэрбум төгрөгийн ашигтай, 25 ХЗХ ашиг, алдагдалгүй, 76 ХЗХ 433.7 сая төгрөгийн алдагдалтай тус тус ажиллаж салбарын хэмжээнд нийт 1.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 19 сая төгрөгөөр буюу 1.18 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хамгийн их ашигтай ажилласан буюу тайлант улиралд 50,000.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний ашигтай ажилласан 6 ХЗХ байгаа бол нийт 287 ХЗХ-ны 26.4 хувь буюу 76 ХЗХ 433.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Алдагдалтай ажиллаж байгаа ХЗХ-дын 73.6 хувь Улаанбаатар хотод, 26.3 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.


Хүснэгт 13: ХЗХ-дын ашгийн хэмжээ /бүлгээр/

Ашгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ / сая төгрөг/	Нийт ашигт эзлэх хувь	Активын хэмжээ / тэрбум төгрөг/	Активын өгөөж
100 саяас дээш	2	811.7	39.9%	50.8	1.6%
50 саяас 100 сая	4	306.6	15.1%	5.6	5.4%
10 саяас 50 сая	24	574.2	28.3%	29.2	1.9%
5 саяас 10 сая	16	124.1	6.1%	3.3	3.8%
1 саяас 5 сая	72	191.7	9.4%	10.4	1.8%
1 сая хүртэл	68	22.9	1.1%	6.9	0.3%
Ашиг, алдагдалгүй	25	-	-	0.8	-
Нийт дүн	211	2031.3	100%	107.1	1.9%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо







ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

6.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

6.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Хөрөнгийн зах зээлийн зуучлал


Санхүүгийн тогтвортой байдлыг хангахад санхүүгийн байгууллагууд чадавхтай байх нь нэгэн чухал үзүүлэлт болдог. Монгол Улсын хувьд цаашид санхүүгийн тогтвортой байдлыг хангахад үнэт цаасны компани(брокер, дилер)–уудын чадавхыг бэхжүүлэх, олон улсын түвшинд хүргэх алхмуудыг хэрэгжүүлэх ёстой.

FTSE болон Russell нь хөрөнгийн зах зээлийн индекс тогтоогч байгууллагууд бөгөөд зах зээлийн тэргүүлэгчид болох зорилгоор хөрөнгө оруулагчдад зах зээлийн талаар бенчмарк тогтоож, дүн шинжилгээ болон тоо мэдээллээр ханган ажилладаг. FTSE нь дэлхийн улс орнуудыг хөгжсөн (developed), эрчимтэй хөгжиж буй (emerging), хоёрдогч эрчимтэй хөгжиж буй (secondary emerging) болон (frontier) зах зээл гэсэн 4 ангилалд хуваадаг. 2016 оны 9 дүгээр сарын байдлаар FTSE–ын Frontier зах зээлийн ангилалд 27 улс орныг багтаагаад байсан. Харин 2017 оны 3 дугаар сард FTSE болон Russell нь улс орнуудын шинэчилсэн ангиллыг урьдчилсан байдлаар гаргахдаа Монгол

Улсыг Frontier зах зээлд багтаах боломжтой орны тоонд оруулаад байгаа бөгөөд 2017 он 9 дүгээр сард эцсийн байдлаар гарахаар хүлээгдэж байна.

“Монголын хөрөнгийн бирж” ХК–д 2017 оны 2 дугаар улирлын байдлаар зуучлалын үүрэг гүйцэтгэгч 61 ҮЦК бүртгэлтэй байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хэмжээг, жилийн арилжааны дүнг олон улсад харьцуулахад бага дүнтэй байдаг. Тиймээс хөрөнгийн зах зээлийн хөгжил сул манай орны хувьд 61 ҮЦК үйл ажиллагаа явуулж байгаа нь хангалттай тоо юу эсвэл бага тоо юу гэдгийг Frontier зах зээл дахь 27 улс орны ҮЦК–ийн тоотой харьцуулав. Харьцуулалт хийх үндсэн шалгуурыг зах зээлийн үнэлгээ болон хүн амын тоо байхаар авч үзэв (дэлгэрэнгүй тоо мэдээллийг нэгдүгээр хавсралтаас харна уу). Frontier зах зээлд багтдаг 27 улс орнуудын зах зээлийн үнэлгээ болон ҮЦК–ийн тоог Зураг 66–д үзүүлэв. Уг ангилалд багтсан улс орнуудын ҮЦК–ний тоо дунджаар 38 байна.

Зураг 66. ҮЦК–ын тоо болон зах зээлийн үнэлгээний хамаарал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Frontier зах зээлд багтсан улс орнуудын хувьд зах зээлийн үнэлгээ болон ҮЦК-ний тооны хооронд шууд эерэг хамаарал ажиглагдаж байна. Энэ нь улс орнуудын хөрөнгийн зах зээлийн хэмжээ томрох буюу нийт зах зээлийн үнэлгээ өсөхөд түүнийг дагаад зуучлалын үүрэг гүйцэтгэх ҮЦК-уудын тоо мөн өсөх хандлагатай байдгийг харуулж байгаа юм. Манай орны хувьд онцгойрогч (outlier) хэлбэртэй байна. Учир нь зах зээлийн үнэлгээ маш бага боловч ҮЦК-ний тоо 61 буюу дундаж үзүүлэлтээс 1.6 дахин их байна.

Хувьцааны үнийн хэлбэлзэл


Дэлхийн улс орнуудын санхүүгийн зах зээлийн хөгжлийг харьцуулахын тулд 2012 онд Дэлхийн банкнаас 4x4 матрицын аргыг ашиглан судалгаа хийсэн байдаг (Demircus, 2012). Уг аргачлалд санхүүгийн зах зээлийг

Санхүүгийн гүнзгийрэлт, Хүртээмж, Үр ашигтай байдал, Тогтвортой байдал гэсэн дөрвөн бүлэгт санхүүгийн хөгжлийг илэрхийлэх 50 хувьсагчийг оруулдаг. Үүнээс хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хэмжихдээ:

- Хувьцааны үнийн индексийн хэлбэлзэл
- Хувьцааны индексийн тархалтын Skewness
- Хувьцааны индексийн бусад улс орнуудын индекстэй хамааралтай байдлаар тус тус авч үзсэн байдаг.

Монголын хөрөнгийн зах зээлийн ТОП-20 индексийн Nikkei 225 болон FTSE 100 индекстэй корреляци хамаарал 2014 оноос өмнө эерэг 70 хувийн хамааралтай байсан бол 2016 онд сөрөг 82 хувийн хамааралтай болж өөрчлөгдсөн, Nikkei 225 болон FTSE 100 индексийн корреляци хамаарал эерэг 70 хувийн түвшиндээ байна.

Зураг 67. Индексүүдийн 5 жилийн гулсах корреляци хамаарал




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн орнуудад зах зээлийн индекс өсөх нь хувьцааны ерөнхий үнэ өсөж зах зээл идэвхтэй байгааг харуулдаг. Хөрөнгийн зах зээлийг тэргүүлэгч орнуудын зах зээлийн идэвхжил нэмэгдэхэд манай орны хувьцааны унах хандлагатай болох нь сөрөг корреляци хамааралтай байгаагаар харагдаж байна. Сүүлийн 3 жил гадаадын хөрөнгө оруулагчид үүсэж буй

(emerging market) зах зээлтэй орнуудаас гарах болсон шалтгаан нь тэргүүлэгч орнуудын хөрөнгийн зах зээл идэвхэжсэнтэй холбоотой байж болох юм.

Хөрөнгийн зах зээлд оролцогчдын хувьд хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшин маш чухал байдаг. Зураг 68-д ТОП-20, Nikkei 225, FTSE 100 индексүүдийн сарын өгөөжийн 6 сарын гулсах дунджийг харуул.

Зураг 68. ТОП 20, Nikkei 225, FTSE 100 индексүүдийн сарын өгөөжийн 6 сарын гулсах дундаж



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Топ 20 индексийн өгөөжийн түвшний хэлбэлзлийг хоёр индексийн хэлбэлзэлтэй харьцуулахад 4.28 хувь, 5.38 хувь, 3.07 хувь (сүүлийн 24 сарын дундаж өгөөжөөс хазайх стандарт хазайлт) байна. Сүүлийн 24 сарын хугацаанд Nikkei 225 илүү хэлбэлзэлтэй байсан бол FTSE 100-ийн хэлбэлзэл харьцангуй бага байсан байна.

6.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын судалгаа

Санхүүгийн зах зээл болон хүн амын эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаатай холбоотойгоор аюулгүй, ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх болон эдийн засгийн шинэ орчинд дасан зохицохын тулд даатгалын салбарт байнгын шинэчлэлт, өөрчлөлтүүд нэвтэрсээр байна. Тодорхой бус байдал нэмэгдэхийн хэрээр төлбөрийн чадварын, хяналтын болон эрсдэлийн удирдлагын шинэ хандлагууд гарч ирэн, зохицуулагч байгууллагууд болон компаниуд өндөр ач холбогдол өгөх болсон.

Энэхүү судалгааны хүрээнд бид даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын одоогийн нөхцөл байдал ямар

байгаа болон ойрын хугацааны түүний хандлагыг илрүүлэх тандалтыг хийхийг зорилго. Судалгааны асуулга 3 хэсгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр хэсэгт, цаашид судалгааны үр дүнг бүлэглэх болон мэдээллийг задлахад ашиглагдах ерөнхий мэдээлэл; хоёрдугаар хэсэгт даатгалын компаниудын салбарын хэмжээнд эрсдэлийн удирдлагын түвшинг хэрхэн харж буйг тандах асуултууд; гуравдугаар хэсэгт, асуулгад хамрагдсан тухайн даатгалын компанийн эрсдэлийн удирдлагын түвшин, түүний хэмжилт, үнэлгээний аргачлалыг тодруулах асуултууд багтсан болно.

Судалгааны түүвэр: Энэхүү судалгаанд ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, давхар даатгалын 1 компани хамрагдлаа.

Судалгаанд хамрагдсан компаниудын ерөнхий төлөв

Судалгаанд хамрагдсан компаниудыг хураамжийн орлогын тархалтаар ангилахад дараах 3 сегментэд хуваагдав. Энд хураамжийн орлогыг 2017 оны 2 дугаар улирлын байдлаар авсан болно.

Хүснэгт 14: Даатгалын компаниудын хэмжээ


Зах зээлд эзлэх хэмжээ	Компанийн тоо	Компанийн ангилал
2 тэрбум төгрөгөөс доош	6	Жижиг
2 – 4 тэрбум төгрөгийн хооронд	4	
4 – 10 тэрбум төгрөгийн хооронд	4	Дунд
10 тэрбум төгрөгөөс дээш	3	Том

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зах зээлд эзлэх хэмжээгээр жижиг даатгалын компанийн ангилалд 10 даатгалын компани буюу 58.8 хувь, дунд хэмжээтэй даатгалын компанийн ангилалд 4 даатгалын компани буюу 23.5 хувь, том хэмжээтэй даатгалын

компанийн ангилалд 3 даатгалын компани буюу 17.6 хувь багтав.

Зураг 69. Судалгаанд хамрагдсан даатгалын компаниудын зэх зээлд эзлэх хэмжээ




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Судалгаанд хамрагдсан бүх даатгалын компаниуд гэнэтийн осол эмчилгээний болон авто тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээг үзүүлж байна. Харин 93 хувь нь хөрөнгийн даатгал, 86 хувь нь хариуцлагын

даатгал, 79 хувь нь ачааны даатгал, 57 хувь нь санхүү, зээл болон барилга угсралтын даатгалын үйлчилгээг үзүүлж байна.

Зураг 70. Даатгалын компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээ




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Судалгааны үр дүн

Стратеги ба хэрэгжүүлж буй арга хэмжээ: Даатгалын компаниуд салбарын хэмжээнд эрсдэлийн удирдлагыг стратегийн зорилт болгон авч үзэж байна хэмээн үзжээ. Хэдий тийм боловч салбарын үйл хөдлөл үүнээс эсрэг үр дүнг харуулж байгаа бөгөөд өөрөөр хэлбэл нийт даатгалын компаниудын 76.5 хувь нь 2017 оны төсөвтөө эрсдэлийн удирдлагад зориулсан хөрөнгө хуваарилаагүй, үүнээс 70.6 хувь нь ирэх 3 жилд төсөвлөхөөр төлөвлөж байгаа гэсэн хариулыг өгчээ. Харин 4 даатгалын компани буюу 23.5 хувь эрсдэлийн удирдлагын санд хөрөнгө төсөвлөжээ.

Эрсдэлийн удирдлагад зориулсан нөөц сангийн хэмжээ өндөр биш байна. Тус санд 50 сая төгрөгөөс доош хөрөнгө төлөвлөсөн болон одоогийн байдлаар бүрдүүлээд байгаа компаниуд нийт даатгалын компаниудын 47 хувийг эзэлж байна. Харин 100 сая төгрөгөөс дээш хөрөнгө бүрдүүлээд байгаа 1 даатгалын компани байв. Үлдсэн 47 хувь нь судалгааны тус асуулыг бөглөөгүй үлдээсэн.

Зураг 71. Эрсдэлийн удирдлагад төсөвлөсөн хөрөнгө




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын салбар дахь эрсдэлийн удирдлагад мөрдөгдөж буй хамгийн чухал 3 зорилгод нэгдүгээрт компанийн эрсдэлийг судлан, хяналт тавих, хоёрдугаарт

СЗХ-оос тавьж буй шаардлага стандартыг мөрдөх, гуравдугаарт олон улсын стандартыг дагаж мөрдөх зэрэг зорилтууд багтжээ.

Зураг 72. Даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын зорилт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Байгууллагын загвар: Даатгалын компаниудын 47.1 хувь нь эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтантай гэсэн бол 11.8 хувь нь зорилго болон чиглэлийг нарийвчлан тодорхойлоогүй боловч эрсдэлийн удирдлагын нэгж

хэлтэстэй, харин 5.9 хувь нь нарийвчлан тодорхойлсон нэгж хэлтэстэй байв. Харин 29.4 хувь нь эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан, нэгж хэлтэсгүй боловч ирэх 3 жилд төлөвлөж байгаа гэжээ.

Зураг 73. Эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан болон нэгж хэлтэсийг стратегид тусгасан эсэх




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үйл ажиллагааны загвар: Даатгалын компаниудын 94.1 хувь нь эрсдэлийн төрлүүдийн талаар ойлголттой гэсэн хариулыг өгсөн бөгөөд төрөл тус бүрээр ойлголтын түвшинг ангилан үзэхэд 81.3 хувь нь даатгалын, зах

зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлийн, 62.6 хувь нь зээлийн, 56.3 хувь нь хөрвөх чадварын эрсдэлийн дундаж ба түүнээс дээш ойлголттой хэмээн хариулжээ.

Зураг 74. Даатгалын компаниудын эрсдэлийн тухай ойлголтын түвшин



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт даатгалын компаниудын 56.3 хувь нь эрсдэлийн удирдлагыг салангид чиглэл болгон үйл ажиллагаа явуулдаг бөгөөд төлөвлөж байгаа гэжээ. Түүнчлэн нийт компаниудын 50 хувь нь эрсдэлээ нарийвчлан тодорхойлж, эрсдэлийн үнэлгээ хийдэг гэсэн бол 37.5 хувь нь үнэлгээний загвартай аж.

Харин эрсдэлийн төрлөөр ангилан үзвэл даатгалын компаниудын 43.8 хувь нь даатгалын эрсдэлээ, 25 хувь нь зах зээлийн, хөрвөх чадварын болон үйл ажиллагааны эрсдэлээ тодорхойлжээ. Харин 31.3 хувь нь даатгалын эрсдэлийн, 18.8 хувь нь зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний загвартай байв.

Зураг 75. Даатгалын компаниуд эрсдэлээ тодорхойлж, нарийвчилсан эсэх




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын компаниудын хувьд үр ашигтай эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэхэд бодлого зохицуулалтаас хамаарсан тодорхой бус байдал хамгийн том тулгамдаж буй асуудалд тооцогдсон бөгөөд нийт судалгаанд хамрагдсан байгууллагуудын 46.7 хувь нь тус бэрхшээлийг онцолжээ. Түүнчлэн өмнөх графикт дурдсанчлан

эрсдэлийн үнэлгээний загвар боловсруулсан даатгалын компани маш цөөхөн байгаа нь нөгөө талаараа даатгалын компаниудад эрсдэлийн болон түүнийг хэмжих аргазүйн тухай мэдлэг дутмаг байгаа нь доорх үр дүнгээс харагдаж байна.

Зураг 76. Үр ашигтай эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хүндрэл




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Мөн даатгалын компаниудаас эрсдэлээс шалтгаалсан жилийн алдагдлаа тооцоолдог эсэхийг асуухад 8 компани ямар нэгэн тоон үр дүн байхгүй гэсэн бол 4 компани зөвхөн зарим бүтээгдэхүүн үйлчилгээн дээр, 3 компани компанийн түвшинд бүтээгдэхүүн тус бүрээр, 1 компани бүтээгдэхүүн тус бүрээр, эрсдэлийн төрөл бүрээр тооцоолол хийдэг гэжээ.

Эрсдэлийн удирдлагын програм хангамж: Судалгаанд хамрагдсан даатгалын компаниудын хувьд эрсдэлийн үнэлгээний холимог аргачлалыг хамгийн өргөн ашиглаж байна. Эрсдэлийн үнэлгээний тресс тестийн тооцооны аргыг нийт компаниудын 25 хувь, бенчмаркинг болон симуляцийн аргачлалыг тус бүр 18.8 хувь, детерминистик тооцооллын аргыг 12.5 хувь нь хэрэглэж байна.

Зураг 77. Ердийн даатгалын компаниудын эрсдэлийн үнэлгээний тооцооллын аргачлал




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин тооцооллын програм хангамжийн хувьд 62.5 хувь нь эксэл дээрх томъёолол ашигладаг бол түүний дараагаар 50 хувь нь өөрсдийн хөгжүүлсэн програм

ашигладаг байв. Харин 12.5 хувь нь програм худалдан авч ашигладаг гэсэн бол үлдсэн 12.5 хувь нь ямар нэгэн програмгүй гэжээ.

Зураг 78. Даатгалын компаниудын эрсдэлийн үнэлгээнд ашиглаж буй програм хангамж




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүгнэлт:

Судалгааны үр дүнгээс харахад даатгалын компаниуд стратегийн хувьд даатгалын эрсдэл болон зах зээлийн эрсдэл чухал ач холбогдолтой гэж үзжээ. Даатгалын компаниудын хувьд даатгалын эрсдэлийн удирдлагатай холбогдох үйл ажиллагаанд хамгийн их хүн цаг буюу дунджаар нийт хүн цагийн 42.1 хувийг, түүний дараа үйл ажиллагааны эрсдэлд 26.8 хувийг зарцуулдаг байна.

Түүнчлэн дээрх 3 эрсдэлийн төрлийн талаар ойлголт даатгалын компаниудын хувь хамгийн өндөр бөгөөд үнэлгээний аргачлал загварчлал бусад эрсдэлийн төрлүүдээс илүү нэвтэрсэн байсан зэргээс үзэхэд эдгээр 3 эрсдэлийг үндсэн тулгамдаж буй эрсдэлээр тодорхойлж болохоор байна.

Зураг 79. Эрсдэлийн төрөл тус бүрийн стратегийн ач холбогдлын түвшин ба түүнд зарцуулж буй хүн цаг



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хэдий даатгалын компаниуд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нь стратегийн үндсэн чухал зорилт хэмээн үзэж байгаа ч, салбарын хэмжээнд эрсдэлийн тухай ойлголт болон түүний үнэлгээний аргачлал, хэмжилзүйн

талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх өөрөөр хэлбэл эрсдэлийн удирдлагыг сайжруулах шаардлагатай байгааг судалгааны үр дүн харуулж байна.

ШИГТГЭЭ 6:

ОЕСД ОРНУУДЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ:

2008–2009 онд банкны салбар хямарч, ихээхэн алдагдалд орсноор санхүүгийн салбарыг хямрал руу хөтөлсөн. Засгийн газрууд санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж үлдэх зорилгоор хямралаас гаргах арга хэмжээнд гол анхаарлаа төвлөрүүлж байв.

Хэдий хямрал банкны салбараас үүсэлтэй байсан боловч банкнаас бусад санхүүгийн байгууллагууд санхүүгийн хямралыг даамжруулахад чухал оролцоотой байсан юм. Санхүүгийн хямралаас хойш бодлого боловсруулагчид Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлд үзүүлсэн нөлөөлөл, учир шалтгааныг тодруулахыг хичээх болсон. Европын холбооны орнуудад тулгарсан үндсэн дөрвөн эрсдэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Нэгдүгээрт, банкнаас бусад санхүүгийн байгууллагууд нь бүтээгдэхүүнтэй холбоотой, ялангуяа хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбогдох эрсдэлийг бий болгодог. 2008 он санхүүгийн хямралаар бид үүнийг тодорхой харсан бөгөөд маш олон банкууд болон банкнаас бусад санхүүгийн байгууллагууд эрсдэлтэй хөрөнгө эзэмшиж болсон. Санхүүгийн хямралын өмнөхөн эдгээр үл хөдлөх хөрөнгө нь санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх бодит эрсдэл болон нүүрлэж байв. Манай улсын хувьд мөн энэхүү эрсдэл банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад нүүрлэх боломжтой тул зээл олгогч санхүүгийн байгууллагуудыг хөрөнгөжүүлж, чадавхжуулах, зах зээлд оролцогчдыг мэргэшүүлэх нэн шаардлагатай байгаа бөгөөд энэ нь улмаар ирээдүйд үүсч болох эрсдэлээс хамгаалах юм.

Хоёрдугаарт, зарим банкнаас бусад санхүүгийн байгууллагууд банкууд болон бусад банк бус санхүүгийн байгууллагуудтай хэт холбоо хамааралтай байдаг нь өөр нэгэн эрсдэл болж байна. Нэг санхүүгийн байгууллагын хямрал бусад санхүүгийн байгууллагуудад дамжин, оролцогч талуудын эрсдэл (counterparty risk)–ийг бий болгон, улмаар санхүүгийн систем бүхлээрээ хямрах талтай байдаг.

Гуравдугаарт, зарим Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хэт өргөжилт. Банк, ББСБ, Даатгал, ХЗХ, Брокер, Дилерийн үйл ажиллагааг цогцоор нь эрхэлж буй санхүүгийн группуд бий болох болсон. Улмаар санхүүгийн нэг салбарт үүссэн хямрал бусад салбартаа дамжих шууд нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. Түүнчлэн хямралд өртсөн томоохон байгууллага бусад санхүүгийн байгууллагуудтай холбогдон, эрсдэл үүсгэх нөлөөтэй тул зах зээлд оролцогчдын тодорхой бус байдал бий болдог. Цаашлаад тодорхой бус байдал өөрөөр хэлбэл үл итгэлцэл нь олон санхүүгийн байгууллагуудыг оролцогч талын эрсдэл үүсгэхэд хүргэж, санхүүгийн системд бүхлээр нь нөлөөлдөг.

Дөрөвдүгээрт, банкнаас бусад санхүүгийн байгууллагууд бүхлээрээ хямралд өртсөнөөр бусад санхүүгийн байгууллагаас авсан өр зээл төлөгдөх боломжгүй болдог. Энэ нь дараах 2 сөрөг үр дагаврыг бий болгоно. Нэгдүгээрт хөрөнгийн үнэлгээг бууруулах шууд нөлөөтэй. Хоёрдугаарт, мэргэжлийн оролцогчид AAA зэрэглэлийн биш хөрөнгөд хөрөнгө оруулалт хийхгүй бөгөөд зөвхөн өндөр зэрэглэлийн хөрөнгө эзэмшигч үйлчлүүлэгчид рүү хандсан үйлчилгээг санал болгодог. Улмаар доогуур зэрэглэлийн хөрөнгийн үнэлгээ буурна. Эргээд энэ нь тус хөрөнгийг эзэмшиж буй санхүүгийн байгууллагуудын балансад нөлөөлдөг.

Эх сурвалж: European Commission

6.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ОУВС–гийн эдийн засагчдын боловсруулсан “санхүүгийн тогтвортой байдлын зураглал”–д санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийг дараах байдлаар тодорхойлжээ.


Үүнд:

- Макро эдийн засгийн эрсдэл
- Гадаад секторын эрсдэл
- Мөнгө, зээлийн захын эрсдэл
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар ба санхүүжилтийн эрсдэл
- Ашигт ажиллагаа ба төлбөрийн чадварын эрсдэл
- Хөрөнгийн үнийн эрсдэл
- Хувийн хэвшил, өрхүүдийн, төлбөрийн чадварын эрсдэл

Банк бус санхүүгийн салбарын хэмжээнд зээлийн эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг 2017 оны 2 дугаар улирлын байдлаар тооцлоо.

Зээлийн эрсдэл: Санхүүгийн байгууллагуудын зээлийн эрсдэлийг илэрхийлэх гол үзүүлэлт болох чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2017 оны 2 дугаар улирлын байдлаар 13 хувь байсан ба энэ нь өмнөх улирлаас 1.1 нэгжээр өссөн үзүүлэлт юм. Салбарын чанаргүй зээлийн хувь арилжааны банкнуудтай харьцуулахад өндөр байгаа ба 2016 оны байдлаар ББСБ–уудын чанаргүй зээлийн хувь 3.3 нэгжээр өндөр байжээ. Арилжааны банкнуудын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 8.2 хувь байсан. Мөн ББСБ–уудын зээлийн эрсдэлийн сангийн чанаргүй зээлд эзлэх хувь 65.6 байна. ББСБ–уудад зэрэглэл тогтоодог PEARLS аргачлалын дагуу зээлийн эрсдэлийн сангийн чанаргүй зээлд эзлэх хувь 100 хувь буюу эрсдэлийн сангаар чанаргүй зээлийг бүрэн хангаж байх шаардлагатай гэж үздэг. Гэтэл ББСБ–уудын эрсдэлийн сангийн харьцаа 65.6 буюу чанаргүй зээлээ бүрэн нөхөж чадахгүй байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Зураг 80: Чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо

Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй нийт 304 ББСБ байгаа ба тэдгээрийн 21 хувь буюу 64–ийн зээлийн нийт үлдэгдэл 50–аас дээш хувийн, 57.6 хувь

буюу 175 нь 5–аас 40 хувь хүртэл, 21 хувь буюу 65 нь 5 хүртэл хувиар хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 15: Зээлийн эрсдэл /ББСБ-уудын тоогоор/


Ангилал	Зээлийн эрсдэл	Хугацаа хэтэрсэн зээлийн хувь	Чанаргүй зээлийн хувь
0.05% – 4.9%	65	94	88
5% – 10%	47	46	40
10.1% – 20%	67	38	51
20.1% – 30%	38	12	26
30.1% – 40%	23	7	18
40.1% – 50%	16	4	14
50.1% – 60%	10	0	9
60.1% – 70%	9	1	5
70.1% – 80%	8	1	3
80.1% – 90%	7	2	8
90.1% – 100%	14	3	5

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл: Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар буцаан олгох чадвартай эсэхийг илэрхийлэх төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг тооцоход

бэлэн мөнгөний харьцаа 100 хувиас бага 74 ББСБ байгаа нь богино хугацаат өр төлбөрөө мөнгөн хөрөнгөөрөө шууд төлөхөд хүндрэлтэйг илтгэж байна.

Зураг 81. Мөнгөн хөрөнгө ба богино хугацаат өр төлбөрийн харьцаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Өр төлбөр нь нийт хөрөнгийнхөө 50-аас дээш хувийг эзэлж байгаа 17 ББСБ байгаа бөгөөд тэдгээрийн 11-ийн

мөнгөн хөрөнгө ба богино хугацаат өр төлбөрийн харьцаа нь хангалтгүй түвшинд байна.

ШИГТГЭЭ 7:

АЛТМАНЫ ИНДЕКС

$$\text{АЛТМАНЫ ИНДЕКС} = 1.2X_1 + 1.4X_2 + 2.3X_3 + 0.6X_4 + 0.999X_5$$

ББСБ–уудын дампуурах магадлалыг тооцдог Алтманы индексийг ашиглан 2017 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 533 ББСБ–ын дампуурах магадлалыг тооцож үзэхэд 2.99–өөс дээш оноо авсан 1, 1.81–2.99–ийн хооронд оноо авсан 344 буюу 64.5 хувь, 1.81–ээс доош оноо авсан 188 буюу 35.3 хувьтай гарлаа.

Иймд нийт ББСБ–ын 64.7 хувь буюу 345–ын үйл ажиллагаа тогтвортой явагдаж байгаа бол 35.3 хувийнх нь үйл ажиллагаа доголдолтой болох магадлалтай.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт: Тусгай зөвшөөрөл эзэмшигч ББСБ–уудын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор баталсан “Банк

бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”–ын дагуу тооцож үзэхэд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 16: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж буй ББСБ–ын тоо

№	Үзүүлэлт	ББСБ–ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ–ын тоо	445	83.5
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ–ын тоо	56	10.5
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ–ын тоо	23	4.3
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ–ын тоо	6	1.1
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ–ын тоо	3	0.6
НИЙТ		533	100


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 533 ББСБ–ын 83.5 хувь нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан бол 10.5 хувь нь 1 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 4.3 хувь нь 2 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 1.1 хувь нь 3 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 0.6 хувь нь 4 харьцаа үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.

6.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тайлант улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт зээл 29 хувиар өсөж 104.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин чанаргүй зээлийн хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21 хувиар буюу 0.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 82: Нийт зээл болон чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

Тайлант хугацаанд өмнөх оны мөн улиралтай харьцуулахад хэвийн зээл 31 хувиар өссөн бол хугацаа хэтэрсэн зээл 6 хувиар буурсан байна. Чанаргүй зээл өмнөх оны мөн үеэс

21 хувиар, тайлант оны өмнөх улирлаас 7 хувиар тус тус өсжээ.

Зураг 83: ХЗХ-дын зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 82.1 тэрбум төгрөг буюу нийт өр төлбөрийн 63.4 хувийг эзэлж байна. Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 1 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 11 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 68.1 тэрбум төгрөг

байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 83 хувийг эзэлж байгаа бол хадгаламж татан төвлөрүүлээгүй 30 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 10.45 хувийг эзэлж байна.

Хүснэгт 17: ХЗХ-дын хадгаламжийн үйл ажиллагаа /тэрбум төгрөгөөр/

№	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн /тэрбум төгрөг/	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10 тэрбумаас дээш	2	43.8	53.4
2	1 тэрбумаас 10 тэрбум	9	24.3	29.6
3	500 саяас 1 тэрбум	5	3.4	4.2
4	100 саяас 500 сая	32	6.6	8.0
5	50 саяас 100 сая	18	1.3	1.5
6	10 саяас 50 сая	105	2.2	2.8
7	5 саяас 10 сая	43	0.3	0.4
8	5 сая хүртэл	43	0.1	0.1
9	Хадгаламжгүй	30	-	-
Нийт хадгаламжийн дүн		287	82.1	100

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо







VII

БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ОРЧИН

БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

7.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

7.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017 оны А-35, 33, 64 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж, хамтран ажиллаж байна.

Дээрх ажлын хэсгийн хүрээнд хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудал, бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний талаарх танилцуулга, санал дүгнэлтийг боловсруулж, мөн санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт тусгуулахаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх стратегийн зорилго, зорилт болон зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд хийгдэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн Сангийн яам, Монголбанкт хамтран “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн талаарх хэлэлцүүлгийг 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдөр салбарын оролцогчдын дунд нээлттэй зохион байгуулсан ба хэлэлцүүлгээс гарсан санал, санаачилгыг хөтөлбөрийн нарийвчилсан төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна.

Хууль зүйн яамнаас ирүүлсэн Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн ажиллагааг Улсын бүртгэлийн газарт шилжүүлэх тухай хуулийн төсөлд СЗХ-ны саналыг хүргүүлсэн.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийг боловсруулах, мэдээлэл өгөх, солилцох, барьцааны мэдэгдлийг бүртгэж дугаар олгох, нийтэд нээлттэй байх болон статистикийн зориулалттай мэдээллийн төрлийг тогтоох журам”-ын төсөлд холбогдох саналыг боловсруулж, Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.

Хууль, дүрэм журмын хүрээнд:

Үнэт цаас зээлдүүлэх, барьцаалах тухай журам: Улсын Их Хурлаас 2015 оны 7 дугаар сарын 02-ны өдөр баталсан Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3-т зааснаар “Зохицуулалттай зах зээл дээрх үнэт цаасыг барьцаалахтай холбогдсон харилцааг энэ хуульд үндэслэн үнэт цаасыг зохицуулах, хянах эрх бүхий байгууллагын тогтоосон журмаар зохицуулна” гэж заасны дагуу Үнэт цаас зээлдүүлэх, барьцаалах тухай журмын төслийг боловсруулах шаардлагатай болсон.

Улсын Их Хурлын 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн хэрэгжиж эхлэх хугацааг 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хойшлуулсан бөгөөд үүнтэй холбогдуулан үнэт цаас зээлдүүлэх зохицуулалтын талаар олон улсын стандарт тогтоогч болон зохицуулагч байгууллагуудаас гаргасан стандарт, зөвлөмжид үндэслэн Үнэт цаас зээлдүүлэх, барьцаалах тухай журмын төслийг боловсруулсан.

Мөн үүсмэл санхүүгийн хэрэгслийн харилцааны нарийвчилсан зохицуулалтыг бий болгох ажлын хүрээнд Люксембургийн Мон-004 төслийн дагуу дотоодын зөвлөхийн боловсруулсан зохицуулалтын журмын төсөлд холбогдох нэмэлт, сайжруулалт хийж, үүнтэй холбоотой судалгаа, олон улсын туршлага /АНУ, Европын холбооны улс, Тайланд/ зэргийг судалсны үндсэн дээр зохицуулалттай зах зээлд арилжих үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх, арилжаанд оролцогчдод тавигдах шаардлагыг тогтоосон “Зохицуулалттай зах зээлд арилжих үүсмэл санхүүгийн хэрэгслийн ерөнхий журам”-ын төслийг боловсруулан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

Зах зээлийн хөгжлийг дэмжих хүрээнд:

Сангийн яамнаас үнэт цаасны төлбөр тооцооны горимыг Т+3 хүртэлх горим болон ДвП төлбөрийн тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсэгт нэрс ирүүлэх тухай 2017.05.05-ны өдрийн 8-1/262 тоот албан бичгийг ирүүлсэн бөгөөд СЗХ-ны зүгээс ажлын хэсэгт холбогдох албан хаагчдын нэрсийг хүргүүлсэн. Үүний

үр дүнд Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017 оны 5 дугаар сарын 25–ны өдрийн 181/297 дугаар хамтарсан тушаалаар мэргэжлийн оролцогчдыг хамруулсан “Хөрөнгийн биржээр дамжуулан хийгдэх үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог Т+3 хүртэлх горим болон ДвП зарчимд шилжүүлэх талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулсан бөгөөд хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх, дараа төлбөрийн горимд шилжих зорилтын хүрээнд үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулаад байна.

Хөрөнгийн зах зээлийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэхээр холбогдох байгууллагуудтай дараах байдлаар хамтарч сургалт, семинар, өдөрлөг, форум, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Үүнд:

Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Дэлхийн банкны техник туслалцааны дэмжлэгтэйгээр “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд олон нийт болон холбогдох байгууллагуудад танилцуулах хэлэлцүүлгийг 2017 оны 3 дугаар сард Төрийн ордны “Иргэний танхим”-д зохион байгуулах ажилд оролцсон.

Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын “Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн багтай хамтран “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Арилжааны төлбөр тооцоо” ХХК, Кастодиан банк болон бусад салбарын оролцогчдын дунд Япон Улс хөрөнгө оруулагчийг хамгаалах санг хэрхэн байгуулсан талаарх туршлага, түүний хамрах хүрээ, зохицуулалтын талаарх семинарыг 2017 оны 4 дүгээр сарын 10–ны өдөр зохион байгуулсан.

Гадаад болон дотоод хамтын ажиллагааны талаар

Япон Улсын ЖАЙКА байгууллагаас СЗХ–той хамтран хэрэгжүүлж буй “Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх” төслийн эхний шат 2017 оны 7 дугаар сараар дуусгавар болж, уг төслийн 2 дахь шат эхлэх гэж байна.

Сангийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 23–ны өдрийн 379 тоот тушаалаар байгуулагдсан “Эрдэнэс Таван толгой” ХК–ийн 1072 ширхэг хувьцааны талаарх асуудлыг эдийн засгийн агуулгаар нь шийдвэрлэх” ажлын хэсэг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, “Эрдэнэс Монгол” ХК, “Эрдэнэс Таван толгой” ХК, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК–уудын төлөөллүүд багтаасан. Ажлын хэсэг 2017 онд 1 удаа хуралдсан бөгөөд ажлын хэсгийн ахлагч өмнөх уулзалтуудаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлуудыг багцлан, холбогдох газруудад өгсөн үүрэг даалгаврыг тодорхойлсон Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулснаа тус уулзалтаар танилцуулсан. Тус тогтоолын төсөлд ажлын хэсгийн

гишүүдийн саналыг тусгасан бөгөөд Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30–ны өдрийн 154 дүгээр тогтоол болон батлагдсан.

7.2 ДААТГАЛ

2017 оны эхний хагас жилд Даатгалын салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, зохистой зохицуулалтыг бий болгох чиглэлээр хэд хэдэн журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, мөн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажлын хэсгүүдэд орж ажиллаа. Үүнд:

Хууль, дүрэм журмын өөрчлөлт:

Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан банк, санхүү даатгалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох Ажлын хэсэгт орж, ажиллан холбогдох бодлогын баримт бичиг боловсруулах даатгалын зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай болон Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах хэлэлцүүлгийг зохион байгуулж, холбогдох санал, зөвлөмжийг Ажлын хэсэгт хүргүүлсэн;

Орон сууцны ипотекийн зээлдэгчдийг хүртээмжтэй, оновчтой хэлбэрээр даатгалд хамруулах чиглэлээр судалгаа хийж, саналыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулсан. “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу уг журмын төсөлд даатгалын зах зээлд оролцогчид, банк, мэргэжлийн холбоод болон олон нийтээс саналыг авч, холбогдох уулзалтуудыг зохион байгуулж ажилласан. Олон нийтээс ирүүлсэн саналуудыг нэгтгэн мөн энэхүү журмын төсөлд “МИК ОССК” ХХК, даатгалын компани болон банкны төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, холбогдох саналыг тусган журмын төслийг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж 2017 оны 109 тоот тогтоолоор “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ыг баталсан.

Хувийн тэтгэврийн даатгалын зохицуулалтын орчныг шинээр бий болгох чиглэлээр Хувийн тэтгэврийн даатгалын тухай хуулийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж хуулийн төслийн эхний хувилбартай танилцан санал солилцож мөн ажлын хэсгийн 2016 онд хийсэн ажлын тайлан материалыг бэлтгэлээ.

Давхар даатгалын чиглэлээр бусад улс орнуудын зах зээлийн нөхцөл байдал, эрх зүйн орчны судалгааг хийсний дагуу Хорооны 2012 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага түүний биелэлтэд хяналт тавих журам”-д өөрчлөлт

оруулах саналыг боловсруулсан байна.

Мөн Хорооны 2008 оны 194 дүгээр тогтоолоор баталсан “Урт хугацааны даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх журам”, 2009 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг сайжруулах чиглэлээр холбогдох судалгааг хийж байна.

Даатгалын сургалт явуулах, даатгалын мэргэжлийн эрх олгох сургалттай холбоотой харилцааг зохицуулсан журмыг шинэчлэн боловсруулж мөн даатгалын сургалтыг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан Хорооны цахим хуудсанд байршуулсан.

Салбарын бодлогын зөвлөлийн гишүүдэд даатгалын салбарт туршлагатай, боловсролтой боловсон хүчнийг нэр дэвшүүлж, нэр дэвшигчдийн товч анкет, холбогдох мэдээллийг цуглуулсан. Даатгалын салбарын бодлогын зөвлөлийг шинэчлэн байгуулах чиглэлээр уг зөвлөлийн харилцааг зохицуулсан журмын төслийг боловсруулаад байна.

Хамтын ажиллагаа:

Жолоочийн даатгалын санд 2017 онд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг даатгагчдын 2016 оны жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлогод тооцсон хураамжийн дүнгийн 1.8 хувиар тогтоохоор санал, холбогдох тооцоо судалгааг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасан сонсох ажиллагааг АЖДХ-той хамтран явуулж, Хорооны дарга, Сангийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдөр “Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчаас жолоочийн даатгалын санд 2017 онд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох тухай” 313/203 тоот хамтарсан тушаалаар батлагдсан.

Хорооны 2015 оны 405, 406, 407, 2016 оны 71 дүгээр тогтоолын хэрэгжилт буюу бүртгэл, зөвшөөрлийг сайжруулах Ажлын хэсэгт ажиллан, Хорооноос даатгалын чиглэлээр олгодог тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн чиглэлийн баримт бичгийн бүрдлийн жагсаалтыг гаргаж ажлын хэсэгт хүргүүлж ажилласан.

ХБНГУ-ын Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй Азийн орнуудад хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо хөтөлбөрийн зүгээс Монгол Улсын хүртээмжтэй даатгалын зохицуулалтын орчны үнэлгээ хийж байгаатай холбоотойгоор даатгалын компани болон даатгалын зууцлагч компаниудын төлөөлөлтэй хийсэн группийн уулзалт, мөн Сангийн яам, Хорооны холбогдох төлөөлөлтэй уулзах уулзалтыг зохион байгуулсан.

“Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан хүртээмжтэй даатгалын жишиг бүтээгдэхүүнийг бий болгох болон

дижитал системийг ашиглан даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх зохицуулалтын орчныг бий болгох” хүрээнд Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс шинэ төсөл авахаар төслийн саналыг боловсруулсан.

Даатгалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох бодлогын баримт бичиг боловсруулах, даатгалын зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай болон Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах хэлэлцүүлгийг мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулж, холбогдох санал, зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт хүргүүлэв.

7.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зохицуулах хороо нь 2017 оны 2 дугаар улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын зохицуулалттай холбоотой “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д 2017 оны 92 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж “дагнан хавсран эсхүл төрөлжүүлэн” эрхлэх гэснийг хасаж, мөн “валют арилжааны ББСБ”, “зээл санхүүжилтийн ББСБ”, “хөрөнгийн удирдлагын ББСБ” гэсэн ангиллуудыг хасаж өөрчлөн баталсан. Мөн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгө, эх үүсвэрийн зөв оновчтой бүтцийг бий болгох, эрсдэл даах чадварыг сайжруулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос 2016 оны 147 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулж “валют арилжааны ББСБ”, “зээл санхүүжилтийн ББСБ”, “хөрөнгө удирдлагын ББСБ” гэсэн ангиллуудыг мөн хаслаа.

Санхүүгийн хүртээмжийг дээшлүүлж, банк бус санхүүгийн байгууллагуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, үйлчилгээний өртгийг бууруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос 2016 оны 271 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг баталсан билээ. Дээрх тогтоолд өөрчлөлт оруулж Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 90 тогтоолоор банк бус санхүүгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 2.5 тэрбум төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 600 сая төгрөг, бусад аймаг, сумдад 200 сая төгрөг болгон шинэчлэн тогтоолоо.




7.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Олон улсын ХЗХ-ны суурь үйл ажиллагааны болон хяналтын үр ашигтай зарчмын хэрэгжилт Хадгаламж зээлийн хоршооны хэрэгжүүлэх Олон улсын суурь

66 зарчмаас бүрэн хэрэгжиж байгаа 40, хэрэгжилт нь хангалтгүй 3, огт хэрэгжээгүй 22 байна.

Зураг 84: Хэрэгжилтийн байдал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-уудад зайны хяналтыг улирал бүр тогтмол хийж, байгууллага болон салбарын үйл ажиллагаа, эрсдэлийг үнэлж ирсэн. Хорооны төсөв санхүү, хүний нөөцийн дутмаг байдал болон хяналт шалгалт хийх шаардлагатай ХЗХ-дын тооноос шалтгаалан газар дээрх хяналт шалгалтад бүрэн хамруулж чадахгүй байдалд хүрсэн.

Иймд Азийн Хөгжлийн Банкнаас 2016–2019 онд хэрэгжүүлэх “Монгол улсын санхүүгийн салбарыг хөгжүүлэх” төслийн хүрээнд олон улсын жишгийн дагуу Эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог нэвтрүүлэхээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

ХАВСРАЛТ

Хавсралт 1: Хөрөнгийн зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012	2013	2014	2015	2016	2017.II
Зах зээлийн үнэлгээ	1,799.90	1,670.50	1,442.60	1,262.50	1,474.20	1,497.6
ЗЗҮ-ний ДНБ-д харьцуулсан хувь	10.7%	8.7%	7.0%	5.4%	6.2%	-
Нийт арилжаа(тэрбум төгрөгөөр): Үүнээс						
Хувьцааны арилжааны хэмжээ	144.7	97.5	24.2	30.4	49	12.2
ЗГҮЦ-ны арилжаа	0.001	1.01	36.11	515.46	299.63	494.0
Компанийн бондын арилжаа	0.31	-	-	0.502	-	6.0
Анхдагч зах зээлийн арилжаа: Үүнээс						
Хувьцаа	0.924	-	2.0	20.1	6.2	-
ЗГҮЦ	-	-	36.1	510.3	280.45	433.9
Компанийн бонд	-	-	-	0.5	-	6.0
Хоёрдогч зах зээлийн арилжаа :Үүнээс						
Хувьцаа	143.82	97.59	22.18	10.36	42.85	12.2
ЗГҮЦ	0.001	1.01	-	5.12	19.1	60.1
Компанийн бонд	0.31	-	-	0.002	-	0.77
Арилжааны хэмжээ /хөрөнгө оруулагчаар/						
Дотоодын иргэн	8.15	5.99	19.66	27.14	28.22	107.7
Дотоодын ААН	2.52	79.55	33.75	510.03	287.65	217.0
Гадаадын иргэн	2.74	2.1	3.14	5.91	6.04	14.9
Гадаадын ААН	131.65	10.97	3.82	3.33	1.82	6.5
Хөрвөх чадвар	8.04%	5.84%	1.68%	2.41%	3.33%	-
Топ-20 индекс	16,839.1	15,874.0	14,833.0	12,279.0	11,605.7	13,610.1
Бүртгэлтэй компанийн тоо	328	323	304	299	302	301
Брокер, дилерийн компанийн тоо	95	87	66	62	62	61
Үнэт цаасны данс эзэмшигчдийн тоо	766,184	775,323	785,863	804,964	886,590	888,879
Хөдөө аж ахуйн биржийн арилжаа	-	403.60	554.09	431.69	463.00	393.36

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хавсралт 2: Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.II	2013.II	2014.II	2015.II	2016.II	2017.II
Хөрөнгө (тэрбум төгрөг)						
Нийт хөрөнгө	97.65	113.22	136.74	170.61	201.40	249.45
Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө	94.01	108.38	130.85	139.84	161.81	200.91
Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгө	3.64	4.84	5.89	6.67	7.36	7.51
Давхар даатгалын компанийн нийт хөрөнгө	*	*	*	24.10	32.23	41.02
Нийт хөрөнгийн өсөлт	26.0%	13.8%	17.2%	19.8%	15.3%	19.3%
Хураамжийн орлого (тэрбум төгрөг)						
Хураамжийн нийт орлого	41.87	42.43	57.07	66.78	61.10	85.54
Ердийн даатгалын компаниудын хураамжийн нийт орлого	41.52	41.95	56.36	65.19	60.51	83.79
Урт хугацааны даатгалын компанийн хураамжийн нийт орлого	0.34	0.48	0.71	0.80	0.59	0.74
Давхар даатгалын компанийн хураамжийн нийт орлого	*	*	*	0.80	0.00	1.01
Нөхөн төлбөр (тэрбум төгрөг)						
Нийт нөхөн төлбөр	6.49	11.80	15.57	18.51	16.20	17.30
Ердийн даатгалын компаниудын нийт нөхөн төлбөр	6.39	11.68	15.30	17.58	15.90	16.64
Урт хугацааны даатгалын компанийн нийт нөхөн төлбөр	0.10	0.12	0.26	0.47	0.45	0.66
Давхар даатгалын компанийн нийт нөхөн төлбөр	*	*	*	0.47	-0.16	0.00
Нөөц сан (тэрбум төгрөг)						
Нөөц сан	46.01	54.06	67.41	74.24	95.90	122.2
Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сан	45.59	53.31	66.23	65.84	81.82	101.9
Урт хугацааны даатгалын компанийн нийт нөөц сан	0.43	0.76	1.18	1.40	1.44	1.40
Давхар даатгалын компанийн нийт нөөц сан	*	*	*	7.00	12.64	18.9
Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөг)						
Давхар даатгалын хураамж	11.26	11.04	17.19	26.03	19.61	35.47
Ердийн даатгалын компаниудын давхар даатгалын хураамж	11.25	11.01	17.19	26.02	19.60	35.03
Урт хугацааны даатгалын компанийн давхар даатгалын хураамж	0.01	0.03	0.01	0.01	0.01	0.01
Давхар даатгалын компанийн давхар даатгалын хураамж	*	*	*	0.01	0.00	0.43
Цэвэр ашиг (тэрбум төгрөг)						
Цэвэр ашиг	3.29	3.48	1.33	2.12	4.39	6.94
Ердийн даатгалын компаниудын цэвэр ашиг	3.35	3.52	1.32	1.92	3.32	4.32
Урт хугацааны даатгалын компанийн цэвэр ашиг	-0.05	-0.04	0.01	0.10	0.08	0.11
Давхар даатгалын компанийн цэвэр ашиг	*	*	*	0.10	0.99	2.50
Цэвэр ашгийн өсөлт	-19.2%	5.3%	-161.4%	37.2%	51.8%	36.7%
Мэргэжлийн оролцогчид (тоо, ширхэг)						
Ердийн даатгал	17	16	16	15	15	15
Урт хугацааны даатгал	1	1	1	1	1	1
Давхар даатгал	*	*	*	1	1	1
Даатгалын төлөөлөгч	2357	3187	3260	3340	3091	3095
Даатгалын зуучлагч	17	20	30	37	40	40
Хохирол үнэлэгч	9	14	20	27	31	31
Актуарч	18	15	15	15	15	16
Аудитор	43	69	84	124	126	126
Аудитын компани	16	22	30	40	42	42

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хавсралт 3: ББСБ-уудын статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.ИИ	2013.ИИ	2014.ИИ	2015.ИИ	2016.ИИ	2017.ИИ
Нийт хөрөнгө	228.8	307.7	443.5	554.5	676.5	855.8
Эргэлтийн хөрөнгө	221.3	297.2	427.4	535.6	650.5	819.7
Мөнгөн хөрөнгө	69.5	83.2	126.9	145.0	207.8	232.8
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2.2	9.4	10.8	11.1	1.3	5.5
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	0.9	0.8	1.3	1.7	2.7	6.0
Эргэлтийн бус хөрөнгө	7.6	10.6	16.4	19.0	26.1	36.1
Нийт өр төлбөр	76.3	109.0	164.1	186.4	169.5	174.4
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	13.6	17.9	24.3	32.5	26.8	34.5
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	45.3	63.5	113.7	123.7	102.0	92.1
Төслийн зээлийн санхүүжилт	5.5	9.6	12.5	14.3	20.1	16.3
Эзэмшигчдийн өмч	152.6	198.7	279.5	368.1	507.0	681.406
Хоёрдогч өглөг	2.6	1.8	1.8	1.7	0.8	0.7
Хувьцаат капитал	129.2	161.0	221.9	285.0	388.8	549.5
Хуримтлагдсан ашиг	16.4	29.2	47.3	72.4	108.2	122.4
ББСБ-ын тоо	198	233	326	423	499	533
Үүнээс: УБ хот		208	289	376	446	467
Хөдөө, орон нутаг		25	37	47	53	66
Харилцагчдын тоо	394,666	471,090	457,540	420,505	420,505	1,353,143
Зээлийн хүүгийн орлого	19.3	29.1	41.3	54.8	64.6	73.6
Үнэт цаасны арилжааны орлого	0.5	0.0003	0.00001	0.00003	0	0
Валютын арилжааны орлого	2.2	1.6	2.1	1.9	1.4	2.2
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл	0.05	0.04	0.4	0.4	1.3	0.08
Нийт орлого	29.8	38.0	63.6	77.2	84.2	89.4
Хүүгийн орлого	20.2	29.3	41.5	55.4	65.5	74.3
Хүүгийн бус орлого	8.8	8.0	21.3	20.9	17.2	12.0
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	0.8	0.6	0.7	0.8	1.5	3.2
Нийт зардал	21.5	25.0	47.6	56.2	59.2	61.4
Хүүгийн зардал	3.0	4.0	6.5	7.0	7.7	6.9
Хүүгийн бус зардал	15.7	17.4	33.3	38.5	37.8	40.0
Болзошгүй эрсдэлийн зардал	1.3	1.6	5.3	7.6	10.0	10.2
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.6	0.4	0.6	0.5	0.6	0.8
Цэвэр ашиг	8.3	13.0	16.0	21.0	25.0	28.1
Нийт зээл	139.2	188.1	259.7	362.3	412.1	554.9
Хэвийн зээл	129.9	174.2	238.2	309.6	331	449.8
Хугацаа хэтэрсэн зээл	3.8	6.9	16.7	24.3	32	33
Чанаргүй зээл	5.5	7.2	15.4	28.4	49.1	72.2
Зээлийн эрсдэлийн сан	4.2	5.1	10.7	21	33.5	47.4

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хавсралт 4: ХЗХ-дын статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛГҮҮД	2012.И	2013.И	2014.И	2015.И	2016.И	2017.И
Нийт хөрөнгө	64.5	71.9	76.8	85.6	105.4	129.5
Нийт хөрөнгө/ДНБ	1.4%	2.1%	3.0%	5.0%	6.0%	9.6%
Мөнгөн хөрөнгө	12.1	11.7	11.1	10.9	19.6	19.3
Нийт зээл	49.3	56.4	61.5	70.8	81.1	104.3
Хэвийн зээл	46.1	53.5	57.9	66.2	73.0	95.7
Хугацаа хэтэрсэн зээл	1.1	1.4	1.8	2.4	4.1	3.8
Чанаргүй зээл	2.1	1.6	1.8	2.2	4.0	4.8
Эргэлтийн бус хөрөнгө	1.4	1.7	2.1	2.3	0.7	3.1
Өр төлбөр						
Хадгаламж	45.2	49.6	52.6	55.8	63.6	82.1
Богино хугацаат зээл	1.4	1.4	0.9	2.1	0.6	2.2
Урт хугацаат өр төлбөр	0.4	0.5	0.4	3.7	14.9	13.2
Бусад богино хугацаат өр төлбөр	2.8	3.8	5.2	4.5	4.7	6.6
Өөрийн хөрөнгө						
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	9.0	9.7	1.3	10.4	11.6	14.0
Хоршоологчдын өмч	5.7	7.0	7.1	8.7	10.0	11.2
Хуримтлагдсан орлого /алдагдал/	0.5	1.6	3.1	3.5	4.6	4.3
Нийт орлого	8.3	8.4	9.2	10.4	11.9	14.1
Хүүгийн орлого	7.5	8.2	8.8	10.0	11.5	13.3
Үйл ажиллагааны бусад орлого	0.5	0.1	0.2	0.2	0.2	0.3
Үйл ажиллагааны бус орлого	0.2	0.1	0.2	0.2	0.2	0.5
Нийт зарлага	6.1	6.6	7.3	9.0	10.3	12.5
Хүүгийн зардал	4.1	4.4	4.7	5.3	6.1	7.3
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	0.2	0.4	0.2	0.9	0.6	1.0
Үйл ажиллагааны зардал	1.5	1.6	2.1	2.6	3.3	3.8
Үйл ажиллагааны бус зардал	0.1	0.0	0.0	0.0	0.1	0.1
Нийт ашиг	2.15	1.86	1.88	1.37	1.62	1.60
ХЗХ-дын тоо	156	142	139	242	277	287
ХЗХ-дын тооны өсөлт	-9%	-9%	-2%	74%	14%	4%
УБ ХЗХ-дын тоо	69	59	57	157	180	191
Орон нутаг ХЗХ-дын тоо	87	83	82	85	97	96
Гишүүдийн тоо /мянга/	27.3	26.4	27.5	35.3	43.8	50.7
Гишүүдийн тооны өсөлт	4%	-3%	4%	28%	24%	16%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Цахим хуудас

www.frc.mn



Холбоо барих

51-264444



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

МЭДЭЭЛЛИЙН СУРВАЛЖ

СТАТИСТИК МЭДЭЭЛЛҮҮД
АВАХЫГ ХҮСВЭЛ

ТУН УДАХГҮЙ



WWW.FACEBOOK.COM

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО



WWW.TWITTER.COM

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО